

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.12.27.

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

1.1. Захиргааны удирдлагын чиглэлээр. Засгийн газраас тогтоосон журмын дагуу байгууллагын 2024 оны зорилт, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүн болон холбогдох бусад бодлогын баримт бичгүүдийг баримтлан баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2024 оны 5 дугаар сард Авлигатай тэмцэх газарт ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай танилцав. Монгол Улсад Авлигатай тэмцэх төрийн тусгай байгууллага үүсэн байгуулагдсанаас хойш анх удаа Монгол Улсын Төрийн тэргүүн байгууллагын үйл ажиллагаатай танилцахаар ирсэн түүхэн үйл явдал болсон бөгөөд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "авлигын гэмт хэргийг илрүүлэх, гадаад улс руу оргон зайлсан этгээд болон гадаад руу хууль бусаар шилжүүлсэн хөрөнгийг буцаан авчрах чиглэлээр ажиллаж байгааг сайшааж, цаашид улс төр, бизнесийн явцуу ашиг сонирхолд үйлчлэх, улс орныхоо язгуур эрх ашгаас урвах, гэмт этгээдэд ял завшуулах, төрийн албаны нэр хүндийг бусдад худалдах, гэмгүй хүнийг хэлмэгдүүлэх, өөрсдөө бусдад худалдагдахын эсрэг байх, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын арга барилаа өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлага байгаа"-г онцлов.

Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан болон Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын нэр бүхий гишүүд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцаж хууль, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд санал солилцлоо.

УИХ-ын дарга Д.Амарбаясгалан "...авлига бол хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил гэдгийг тодотгоод Монгол Улсад өргөн хэрэглэгдэж байгаа 318 хуулийн зүйл, заалт тус бүрд судалгаа хийхэд хүний эрхийн зөрчилтэй 800 гаруй заалт байгааг тогтоосон учраас энэ парламент тэдгээр зүйл заалтыг засахаар ажиллаж эхэлсэн..." талаар, нийгмийн харилцааны 70 хувийг журмаар зохицуулж байгаа нь авлига үүсэх, албан тушаалаа урвуулан ашиглах үндэс суурь болж буйг дурдав. УИХ-аас 2023 онд батлагдсан 2023-2030 онд хэрэгжих "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", 2024 онд батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа УИХ-д, олон нийтэд илүү мэдээлж байх, авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд анхаарлаа хандуулан ажиллах талаар үүрэг болголоо.

Авлигын гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэхийн тулд гадаад улс дахь авлигын гэмт хэрэг үйлдэх замаар олсон хууль бус хөрөнгийг буцаах ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид үндэслэн хэрэгжүүлснээр 2020 оноос хойш нийт 13.9 сая ам.долларын хөрөнгийг Монгол Улсад буцаан авчирч, улсын орлого болгоод байна.

Тайлант хугацаанд Дэлхийн банкны 19.5 сая ам.долларын санхүүжилттэй "Цахим эрүүл мэнд" төсөл 6 жил үргэлжилсэн ч үр дүн гараагүй бөгөөд аудитын дүгнэлтээр хангалтгүй үнэлэгдсэнтэй холбогдуулан Дэлхийн банкнаас уг төслийг зогсоож, улмаар Монгол Улсын Засгийн газраас нийт 1.7 сая ам.долларыг нэхэмжилсэн. Тус газрын Гүйцэтгэх ажлын хэлтэс, Мөрдөн шалгах хэлтсээс Дэлхийн банктай мэдээлэл солилцох замаар гадаад улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажилласнаар төслийн гүйцэтгэгч БНСУ-ын "Taihan Cable & Solution" компани нь хуурамч баримт бичиг бүрдүүлэх замаар төслийн сонгон шалгаруулалтад шалгарч, улмаар гэрээнд тусгагдсан төслийн хөрөнгийг үр дүнгүй захиран зарцуулан улсад их хэмжээний хохирол учруулсан болохыг тогтоон тус

компаниас 1.7 сая ам.долларын хохирлыг Монгол Улсад эргүүлэн төлүүлж, төсвөөс дээрх зээлийн төлбөрийн хүүг төлж байсныг зогсоолоо.

Одоогийн байдлаар авлигын гэмт хэргийн улмаас хулгайлагдсан, Бүгд Найрамдах Латви Улсын нэр бүхий банканд дахь дансанд битүүмжлэгдсэн байгаа 540,307.00 (таван зуун дөчин мянга гурван зуун долоо) еврог Монгол Улсад буцаахаар ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан тул тусгагдсан арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн баталлаа. Тус хорооны дэд даргаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, олон нийтэд мэдээлэх чиг үүрэгтэйгээр Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлтсийн дарга ажиллаж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээнээс Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторинг хийх үнэлгээний баг Монгол Улс (Авлигатай тэмцэх газар)-д 2024 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд ажиллаж, холбогдох зохион байгуулалтыг хариуцан гүйцэтгэлээ.

Олон улсын шинжээчид Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторинг хийх ажлын хүрээнд Монгол Улсын авлигатай тэмцэж буй бодлого, шүүх эрх мэдлийн байгууллагын болон прокурорын байгууллагын бие даасан байдал, шүгэл үлээгчийн эрх зүйн байдал, бизнесийн шударга байдал, ашиг сонирхлын зөрчил ба хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, авлигатай тэмцэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, авлигын гэмт хэргийн ял оногдуулалт зэрэг нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн бөгөөд 34 байгууллагын 165 албан тушаалтан үнэлгээнд хамрагдаж Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцооны талаарх мэдээллийг өгөхийн зэрэгцээ шинжээчдийн асуултад хариулж тодорхой тодруулгыг өгсөн.

Олон улсын шинжээчдийн багаас Монгол Улсад ажиллах үеэр эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас өгсөн болон нэмэлтээр хүргүүлсэн мэдээлэл, холбогдох бусад баримтад үндэслэсэн нэгдсэн тайланг тус Сүлжээний Жилийн бүгд хурлаар 2024 оны 9 дүгээр сард нийт гишүүн улсуудад танилцуулснаар тайланг хамгааллаа.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-тай хамтран 2024 оны 3 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилт, Хөрөнгө хураах тогтолцоо, Авлигаас урьдчилан сэргийлэх сэдэвт 3 бага хурлыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газар болон холбогдох төрийн, төрийн бус байгууллагын 105 төлөөлөгчийг хамруулав. Бага хурлаар дэлхийн улс орнуудын авлигын эсрэг бодлого, тогтолцооны дутагдал, хүндрэл бэрхшээл, Монгол Улсын авлигын эсрэг шинэ стратеги, авлигаас урьдчилан сэргийлэх талаар санал солилцож, хөрөнгө буцаах олон улсын сайн туршлагыг танилцуулж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдвэл зохих ажил, арга хэмжээг тодорхойллоо.

Дэлхийн банк болон Монгол Улсын Засгийн газар хоорондын “Ухаалаг засаг” төслийн хүрээнд [mediuleg.iaac.mn](http://mediuleg.iaac.mn), [iad.iaac.mn](http://iad.iaac.mn); e-office, [smart.iaac.mn](http://smart.iaac.mn), [search.iaac.mn](http://search.iaac.mn), [hasxom.iaac.mn](http://hasxom.iaac.mn) гэх цахим системүүдийг интеграцичлах, үйл ажиллагааг хөнгөвчлөх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, системийн хэвийн найдвартай аюулгүй байдлыг хангах төслийн 2 дугаар үе шатанд “Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын цогц цахим систем”-ийн програм хангамжийг хөгжүүлэх, холбогдох тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбоотой ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг эцэслэн боловсруулав. Улмаар тендерийн баримт бичгийг боловсруулах, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог “Ухаалаг засаг” төслийн нэгж, Цахим

хөгжил, инновац, харилцаа холбооны яамны оролцоотойгоор байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан. Одоо гэрээ байгуулах ажил Төслийн нэгжид төвлөрөн үргэлжилж байна.

“Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2024”-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг эмхэтгэн Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлөөс гаргасан хүсэлтийн дагуу 2023 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад мэдээллийг танилцуулж, хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах журам”, холбогдох маягт, жагсаалтыг баталсан бөгөөд тус журамд нийцүүлэн “Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт нөхөх заавар”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт нөхөх заавар”, “Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт нөхөх заавар”-ыг баталлаа.

Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлээд байна.

Эрүүгийн хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт эрх бүхий албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд эдгээр хууль болон холбогдох хууль, журмын төсөлд тусгавал зохих саналуудыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлав.

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдлээ.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг баримтлан байгууллагын мэдүүлэг гаргавал зохих албан хаагчдын 2023 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэчилсэн бүртгэлийн тухай мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 05, 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 73 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн “Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдлын талаар”, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, ХАСХОМ-ийн тайлан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг боловсруулан Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Байгууллагын хэмжээнд 2024 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гаргасан 2946 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэс 1789 буюу 61.0 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс 828 буюу 28.1 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэс 146 буюу 5.0 хувь, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс 115 буюу 3.9 хувь, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын алба 66 буюу 2.2 хувь, Тамгын хэлтэс 2 буюу 0.1 хувийг хянан шалгасан байна.

Байгууллагын өргөдөл, гомдол, мэдээллийн менежментийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээний хүрээнд орон тоо, зохион байгуулалтыг өөрчлөх, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-ийн “Авлигыг мэдээлэх механизмыг боловсронгуй болгох нь” төсөлтэй хамтран ажиллах зэргээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэв. НҮБ-ын Хөгжлийн

хөтөлбөр (UNDP)-ийн "Авлигыг мэдээлэх механизмыг боловсронгуй болгох нь" төслийн хүрээнд байгууллагын өргөдөл, гомдлын "Smart office" системд хөгжүүлэлт, интеграци хийж, all/call програмыг үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна. Энэхүү програмыг нэвтрүүлснээр 110 тусгай дугаарын утсаар өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажиллагаанд дэвшил гарч, чанаргүй дуудлагын тоо цөөрч, хийдэл болон зохиомол ачаалал буурсан эерэг үр дүн гарч байна.

### **Хоёр. Гадаад харилцааны чиглэлээр**

2024 онд байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэх, Авлигын эсрэг конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын болон гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай нягт хамтран ажиллалаа.

Малайз Улсын Авлигатай тэмцэх хорооны тэргүүн комиссар Тан Шри Азам Бин Бакигийн урилгаар Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 2 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд тус улсын Авлигатай тэмцэх хороонд албан ёсны айлчлал хийж, авлигатай тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээг танилцуулан, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, энэ хүрээнд авлигатай тэмцэх чиглэлээр "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулах, байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр тус улсын Авлигын эсрэг академитай хамтран ажиллахаар тохирлоо.

Тайландын Хаант Улсын Авлигатай тэмцэх Үндэсний хороотой "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Самоа Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн хоёрдугаар шатны үнэлгээний багийн бүрэлдэхүүнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), Папуа Шинэ Гвиней Улсын шинжээчидтэй хамтран ажиллаж, Самоа Улсын хөрөнгө буцаах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаарх тайланг үнэлж, үнэлгээний тайлан, зөвлөмжид тусгуулах саналыг бэлтгэн НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-нд хүргүүлэв.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хорооны 50 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан чуулган, БНФУ-ын Парис хотноо зохион байгуулагдсан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Үндэстэн дамнасан авлигын гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулагчдын дэлхий нийтийн сүлжээ (GLEN)-ний VI удаагийн уулзалт, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар (UNODC), Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга (StAR), Нээлттэй өмчлөгч (ОО), Бүгд Найрамдах Индонез Улсын Хууль, хүний эрхийн яам (MLHR) хамтран зохион байгуулсан "Бүс нутгийн үе тэнгийн солилцоо: Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах замаар Зүүн Өмнөд Ази дахь авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах нь" сэдэвт хэлэлцүүлэгт албан хаагчид оролцлоо.

2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр зохион байгуулагдсан Ази, Номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллага хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн хуралд оролцож, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

БНХАУ-д 2024 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Авлигатай тэмцэх байгууллага хоорондын дэлхийн сүлжээ (GlobE)-ний V Жилийн бүгд хурал, Арабын Нэгдсэн Эмират Улсад зохион байгуулагдсан Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ийн 2024 оны жилийн чуулга уулзалт, Бүгд Найрамдах Азербайжан улсад 2024 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулагдсан тус холбооны 29 дүгээр Жилийн чуулган, Бүгд Найрамдах Латви Улсад 2024 оны 10 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээний 14 дүгээр уулзалтад төлөөлөгчид оролцсоны зэрэгцээ хурал, чуулганы үеэр гадаад улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, олон улсын байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудтай хоёр талын болон олон талт уулзалт хийж, авлигын эсрэг олон улсын хамтын ажиллагааны талаар санал солилцож, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр харилцан байр сууриа илэрхийллээ.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нар олон улсын болон гадаад улс орны эрх бүхий албан тушаалтнуудтай албан уулзалт хийж, авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, ололт, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, ижил төстэй чиг үүрэг бүхий холбогдох

байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, харилцан туршлага судлах, авлигатай тэмцэх чиглэлд хамтран хэрэгжүүлэх төслийн талаар, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах, тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй зарим хэрэгт эрх зүйн харилцан туслалцаа авах чиглэлд анхаарч ажиллах талаар санал солилцож, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр харилцан тохиролцов. Тухайлбал,

- Тэргүүн комиссар З.Дашдаваа Азийн сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Сара Л.Тайлорыг хүлээн авч уулзан Суурин төлөөлөгчөөр томилогдсон явдалд баяр хүргэн Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.
- Дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал нар АНУ-ын Хууль зүйн яамны Гадаад дахь прокурорын сургалт, хөгжлийн төвийн бүс нутаг хариуцсан захирал, хатагтай Еэ Тинг Воог хүлээн авч байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах төслийн талаар, АНУ-ын Холбооны мөрдөх товчооноос Бээжин хотод суугаа Хуулийн дэд атташе Жошуа Лесиертэй уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, байгууллагын 2 албан хаагчийг Холбооны мөрдөх товчооны Үндэсний академид суралцуулахаар тохирлоо.
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Эдийн засаг, хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн зохицуулагч Бакыт Жузупов, АНУ-ын Төрийн Департаментын Олон улсын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх товчооны ахлах ажилтан Матью Киллиан, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны орон тооны бус хуулийн зөвлөхөөр томилогдсон хатагтай Женифер Валес, тус Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын хэлтсийн мөрдөх ажил хариуцсан атташе Клиффорт Китто, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны Зүүн Өмнөд Ази, Номхон далайн бүсийн төлөөлөгч, ноён Масуд Каримипур нарыг хүлээн авч уулзан сайн засаглал, авлигатай тэмцэх үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах талаар хэлэлцэж, санал солилцов.
- Европын холбооны эрх бүхий албан тушаалтантай Монгол Улсын Засгийн газарт 2020-2025 онд 43 сая еврогийн буцалтгүй тусламжийн төсвийн дэмжлэгийг олгож байгаа асуудлаар, авлигын нөхцөл байдал, авлигаас урьдчилан сэргийлэх төсөл, арга хэмжээний талаар Азийн хөгжлийн банкны Авлигатай тэмцэх, шударга байдлын газрын ахлах шударга байдлын шинжээч, хатагтай Жануари Агбон Санчез, Ноён Марк Эммануал Аяес нартай, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын төв штабын Хяналт, үнэлгээний мэргэжилтэн Алессандро Грилло нарын төлөөлөгчидтэй, “Монгол Улсын Институтийн шударга байдлыг хангах төсөл”-ийн II шатны бэлтгэл ажлыг хангах хүрээнд Азийн хөгжлийн банкны Монгол Улсын Засаглалын үнэлгээг хийх төлөөлөгчидтэй тус тус уулзаж, тус хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн төслийн үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярилцаж санал солилцов.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Зүүн Өмнөд Ази, Номхон далайн бүс нутгийн Бангкок хот дахь төлөөлөгчийн газар болон Тайланд Улсын Авлигын эсрэг үндэсний хороо хамтран Зүүн Өмнөд Ази дахь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор зохион байгуулсан бүс нутгийн платформыг идэвхжүүлэх бага хуралд албан хаагчид оролцлоо.

Мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр гадаад улс орон, олон улсын байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчдыг өргөнөөр хамруулах бодлого баримтлан ажиллалаа. Албан хаагчид (биечлэн болон цахимаар)-ыг 2024 онд дараах сургалтуудад хамруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авлаа. Үүнд:

- БНЭУ-ын Эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллага (ИТЕС)-аас зохион байгуулсан “Кибер гэмт хэрэг мөрдөн шалгах” сэдэвт сургалт;
- “Ажлын байрны соёлыг сайжруулах замаар үр дүнг нэмэгдүүлэх нь” сэдэвт олон улсын сургалт;
- АНУ-ын Жеоржиа мужийн Холбооны Хууль сахиулах сургалтын төвд “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа ба дүн шинжилгээ” сэдэвт сургалт;
- “Криптовалютыг гэмт хэргийн шугамаар ашигласан явдлыг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт;

- АНУ-ын Олон улсын хууль сахиулах академид 2024 оны 6 дугаар сарын 3-7-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Криптовалютыг гэмт хэргийн шугамаар ашигласан явдлыг мөрдөн шалгах нь” сэдэвт сургалт;
- ОУВС (IMF)-гаас зохион байгуулсан “Макро түвшний авлигатай тэмцэх нь” сэдэвт сургалтад суралцаж, БНХАУ-ын Сахилгын хяналтын академиас зохион байгуулсан “Бүс ба замын түншүүдийн авлигын эсрэг семинар”-т албан хаагчид хамрагдаж, туршлага судаллаа.
- Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас зохион байгуулсан “Авлига ба жендерийн асуудлаарх бүс нутгийн яриа хэлэлцээ: Үйл ажиллагаанд хамруулах нь” сургалт, хэлэлцүүлэгт нэр бүхий албан хаагчид оролцож, Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-тай хамтран Монгол Улсад анх удаа хийгдсэн “Авлига ба жендер” судалгаанд үндэслэн “Монгол Улс дахь авлига ба жендерийн харилцан хамаарал” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн нь онцлог байлаа.

Олон улсын байгууллагатай хамтран Авлигатай тэмцэх газрын төдийгүй төрийн бусад байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалт, хурлыг зохион байгуулсан нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа болон үйл ажиллагааны уялдааг хангасан үр дүнтэй сургалт боллоо гэж дүгнэж байна. Үүнд:

- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран “Авлигыг илрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн үүргийг нэмэгдүүлэх нь” сэдэвт бага хурлыг зохион байгууллаа. Хуралд Авлигатай тэмцэх газар болон холбогдох төрийн, төрийн бус байгууллагын 45 төлөөлөгчийг хамруулсан бөгөөд харилцан туршлага солилцож, тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээг тодорхойллоо.
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай хамтран “Виртуал хөрөнгө болон блокчэйнд суурилсан санхүүгийн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газрын албан хаагчид болон төрийн байгууллагын 28 албан хаагчийг хамруулав.
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран “Хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагаагаар авлигын мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж Авлигатай тэмцэх газрын болон Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар болон Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны 32 төлөөлөгчийг хамруулав.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны “Globe” сүлжээ болон Олон улсын прокуроруудын холбооноос хамтран 2024 оны 3 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулсан “Спортын авлигын хэргийг шүүхээр шийдвэрлэх нь” сэдэвт цахим семинарт байгууллагын 13, Малайз Улсын Авлигын эсрэг хорооноос НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны “Globe” сүлжээтэй хамтран 2024 оны 3 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Малайзын 1MDB-тэй холбогдох хэргийг шалгахад олон улсын хамтын ажиллагааны чухал үүрэг” эдэвт цахим семинарт 11, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны “Globe” сүлжээнээс Молдав Улсын Авлигатай тэмцэх газартай хамтран 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулсан “Молдав Улсаас гэмт хэргийн замаар хулгайлагдсан их хэмжээний хөрөнгийг олон улсын хэмжээнд мөрдөн шалгаж байгаа байдал” цахим танилцуулга сургалт-семинарт 9 албан хаагч тус тус хамрагдаж, туршлага судаллаа.

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага нь АНУ-ын Засгийн газар Төрийн Департаментын дэргэдэх Олон улсын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” төслийг 2021-2024 оны хооронд хэрэгжүүлж дууссан ба дээрх төслийн үр дүнд үндэслэн төслийн II шатыг 3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний саналыг хүргүүлсэн.

## Гурав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр:

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсантай холбогдуулан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, улсын хэмжээнд хэрэгжүүлэгч байгууллагуудын болон хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны 2 удаагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэл ажлыг хангаж, дараах асуудлуудыг шийдвэрлүүлэв. Үүнд:

- ISO37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог төрийн өмчит хуулийн этгээдэд нэвтрүүлэх тухай;
- Төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах тухай;
- Мэдээллийн ил тод байдлыг сайжруулах тухай;
- Алдагдалтай ажилласан төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны аудитын үнэлгээнд үндэслэн авах арга хэмжээний тухай;
- Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах тухай;
- Үндэсний шударга байдлын тогтолцооны үнэлгээ хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах Зөвлөлдөх хороо байгуулах тухай;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах тухай.

Үндэсний хорооны шийдвэрийг сурталчлах, олон нийтэд танилцуулах, мэдээ, мэдээллээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна.

Хөтөлбөрийн Зорилт 1.4-ийн “Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахуйц эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлэх, сонгуулийн болон сонгуулийн бус үеийн санхүүжилтийг ил тод болгож, сонгуулийн зардлыг бууруулан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хамгаалах, нэр дэвшигчдийг өрсөлдөх тэгш боломжоор хангах” хүрээнд “Иргэд, сонгогчийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө”-г батлав. Төлөвлөгөөнд зааснаар Монгол Улсад иргэд, сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх талаар хийгдсэн ажил, арга хэмжээний нөхцөл байдлын судалгааг хийлээ.

Энэ чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэхээр тайлант хугацаанд Жендерийн үндэсний хороо, “Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан” ТББ-ын төлөөлөлтэй уулзалт хийж, хамтын ажиллагааны талаар санал солилцон, “Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан” ТББ-аас хэрэгжүүлэх “Авлигагүй нийгмийн төлөөх иргэний нийгмийн санаачилга” төсөлд хамтран ажиллав.

“Авлигагүй нийгмийн төлөөх иргэний хяналт” сэдэвт 3 модуль бүхий сургалтын хөтөлбөр, модуль, гарын авлага боловсруулан, гарын авлагад үндэслэн нийслэл болон 21 аймаг дахь гишүүн байгууллагуудын төлөөлөл, зохион байгуулагч нийт 35 хүнийг хамруулан сургалт зохион байгуулав. Сургалтын хөтөлбөрийн дагуу оролцогчид иргэдийн оролцооны ач холбогдол, тэдгээрийн авлигын эсрэг үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг SWOT шинжилгээний аргаар тодорхойлох, Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах талаарх сайн туршлагыг хуваалцах, авлигын эсрэг кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах дасгалуудыг багаар гүйцэтгэн, гарын авлагад орсон сургалтын арга, аргачлалыг туршсан ач холбогдолтой сургалт боллоо.

Авлигын эсрэг үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулах зорилгоор олон улсын байгууллагаас гаргасан “Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд залуучуудын үр дүнтэй оролцоог хангах нь” гарын авлагыг орчуулж, гарын авлагын дагуу туршилт сургалтыг зохион байгуулж, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх, иргэдийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын модуль, гарын авлагыг боловсруулах, сургалт зохион байгуулах ажлыг төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэлээ.

“Авлигын эсрэг залуусын оролцоог нэмэгдүүлэх” сэдэвт хакатон тэмцээнийг “Бодлогод залуусын хяналт” ТББ, “Үүр төв” ТББ-тай хамтран зохион байгууллаа. “Бодлогод залуусын хяналт” ТББ-аас

санаачлан Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран зохион байгуулсан “Дата эрх чөлөө: Сонгуулийн 2024” үзэсгэлэнд “Авлигын эсрэг дата үзэсгэлэн”-г гаргаж, олны хүртээл болгов.

Хөтөлбөрийн Зорилт 1.4, 3.2, 3.3, 9-ийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх, үр дүнтэй хяналтын механизмыг сайжруулах үндсэн зорилго бүхий “Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах нь” төслийг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл дараах 4 хөтөлбөрөөс бүрдэж байна. Үүнд:

- Төрийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах хөтөлбөрүүд;
  - Төрийн бодлогыг боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх хөтөлбөр;
  - Авлигатай тэмцэх, сонгогчийн боловсрол, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх (иргэн, иргэний нийгмийн байгууллагын эвсэл, сүлжээ, сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр бүхий) хөтөлбөр;
- Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр;
- Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр;
- Иргэдийн шүгэл үлээх, мэдээлэх соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр.

“Эмэгтэйчүүд, залуучууд оюуны сан” ТББ-тай хамтран төрийн албан хаагч, удирдах албан тушаалтнуудыг үндэсний сургагч багш, ментороор бэлтгэж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2, 3 болон 9 дүгээр зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Авлигаас ангид нийтийн алба: Авлигын эсрэг төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт ментор сургалтыг зохион байгуулж, төрийн албан хаагчийн манлайллын хөтөлбөрийн төгсөгчдийн төлөөлөл болон төрийн бус болон төрийн байгууллагын удирдах ажилтан 30 хүнийг хамрууллаа.

Үндэсний шударга ёсны түвшний 4 суурь, 13 тулгуур баганад үүнээс “шүүх засаглал, хууль хяналтын байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага” гэсэн 4 баганын үнэлгээний судалгааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, шүүх засаглал, хууль хяналтын байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, гүйцэтгэх засаглал, нийтийн алба, аудитын төв байгууллага, сонгуулийн төв байгууллага, улс төрийн нам гэсэн 9 баганын үнэлгээний судалгааг зохион байгуулан, тайланг хүлээн авч, үнэлгээнд хянан магадалгаа хийлгүүлэх, хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт авахаар холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

Хөтөлбөрийн Зорилт 2.6-ын хүрээнд “Шударга байдлын үнэлгээ болон Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаагаар эрсдэлтэй үнэлгээ авсан төрийн байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөөг баталлаа.

2023 оны Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага үнэлгээ авсан Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Завхан, Хэнтий, Төв, Ховд, Увс, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж, нөхцөл байдлын талаар хэлэлцэн “Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байна.

Дээрх 10 байгууллагын “Шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний тусгайлсан төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийлээ. Тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлсэн дээрх 10 байгууллагаас Завхан (-3.7), Ховд (-7) аймгийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээ 2024 онд буурсан бол бусад 8 байгууллагын үнэлгээ 0.2-8 оноогоор өссөн эерэг дүнтэй гарсан байна. Төв аймгийн Засаг даргын Тамгын газар (+84.4), Нийгмийн даатгалын ерөнхий газар (+74.5)-аас бусад байгууллага нь улсын дундаж (72.6)-аас доогуур үнэлэгдсэн бөгөөд Завхан, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газраас бусад 8 байгууллага нь 2024 оны үнэлгээгээр хамгийн бага оноотой 10 байгууллагын жагсаалтад ороогүй байна. 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналыг боловсруулах ажил хийгдэж байна.



Шүүх, хууль хяналтын 9 байгууллагын хүрээнд хийгдсэн төсөөллийн судалгаагаар авлигын цар хүрээ “Их” гэж үнэлэгдсэн байгууллагуудад эрсдэлийг бууруулах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, энэ чиглэлээр 2024 онд хэрэгжүүлбэл зохих ажил, арга хэмжээг тусгайлсан төлөвлөгөөнд тусгууллаа. Судалгаагаар авлигын цар хүрээ “Их” гэж үнэлэгдсэн Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийж, судалгааны үр дүнгийн мөрөөр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, судалгааны үр дүнг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, арга зүйн зөвлөмж, мэдээлэл, танилцуулгыг гардуулсан.

Тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлж буй байгууллагуудаас төлөвлөгөөний биелэлттэй сар тутамд дүн шинжилгээ хийн мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Тухайлбал шүүх, хууль хяналтын 9 байгууллагын хүрээнд хийгдсэн төсөөллийн судалгаагаар авлигын цар хүрээ “Их” буюу 4.06 баллаар үнэлэгдсэн цагдаагийн байгууллагад авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан ба төлөвлөгөөний дагуу уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Шүүх, хууль хяналтын байгууллага дахь авлигын талаарх төсөөллийн индекс”-ийг сайжруулах чиглэлээр ажил арга хэмжээний төлөвлөгөөг тусгуулан батлуулав. Энэ хүрээнд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх шийдвэр гүйцэтгэгчдийг хамруулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хийлээ.

Хөтөлбөрийн Зорилт 3.3.1 буюу Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд иргэний нийгмийн байгууллагын сүлжээ үүсгэж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор авлигатай тэмцэх чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж буй 90 төрийн бус байгууллагын жагсаалт гарган сан үүсгэж, “Шүгэл үлээгчид” ТББ, “Бодлогод залуусын оролцоо”, Жендерийн үндэсний төв, Засаглал судлалын үндэсний хүрээлэн, Бизнесийн ёс зүйн төв, Сонгогчдын боловсрол төв, Нийгэм улс төрийн боловсрол төв, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Лийд төгсөгчдийн холбоо, Монголчуудын үзэл санааны нэгдэл зэрэг байгууллагуудтай сүлжээ үүсгэж, хамтран ажиллах асуудлаар санал солилцож, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгөв.

Тайлант хугацаанд “Авлигатай тэмцэхэд олон нийтийн оролцоог хангах нь” төслийн хүрээнд “Авлигатай тэмцэх, сонгогчийн боловсрол, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх иргэн, иргэний нийгмийн байгууллагын эвсэл, сүлжээ, сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр”-т зааснаар авлигатай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эвсэл, сүлжээнд нэгдэн ажиллах хүсэлтэй төрөл бүрийн салбар дахь иргэний нийгмийн сүлжээнд 16 иргэний нийгмийн байгууллага нэгдлээ. Иргэний нийгмийн оролцоог хангах, тэдний чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Авлигын эсрэг иргэний эрхэм үүрэг” сэдэвт сургалтын 4 модуль хөтөлбөрийг боловсруулж, 60 хүнд туршилт сургалт зохион байгуулав.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, түүний ач холбогдол, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх арга замуудын талаар оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх ур чадвар эзэмшүүлэх зорилгоор “Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан” ТББ-тай гэрээ байгуулан “Авлигагүй нийгмийн төлөөх иргэний хяналт” сэдэвт 3 модуль бүхий сургалтын хөтөлбөр, модуль, гарын авлага боловсруулав. Тус сургалтын хөтөлбөрт үндэслэн авлигын эсрэг үндэсний сүлжээний нийслэл болон 21 аймаг дахь гишүүн байгууллагуудын төлөөлөл, зохион байгуулагч нарын 35 хүнийг хамруулан сургалт зохион байгуулав. Сургалтаар иргэдийн оролцооны ач холбогдол, тэдгээрийн авлигын эсрэг үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг SWOT шинжилгээний аргаар тодорхойлох, Иргэдийн хяналтын бүлгийг байгуулах талаарх сайн туршлагыг хуваалцах, авлигын эсрэг кампанит ажлын төлөвлөгөө боловсруулах дасгалуудыг багаар гүйцэтгэн, гарын авлагад орсон сургалтын арга, аргачлалыг туршсан ач холбогдолтой сургалт боллоо гэж үзэж байна.

Хөтөлбөрийн зорилт 3.3.1.5 буюу “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөөг баталж, 21 аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нараас олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах ажил, арга хэмжээг төлөвлөх, өнөөгийн нөхцөл байдал, учирч буй хүндрэл бэрхшээлийг тогтоох, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор асуумж авч, дүн шинжилгээ хийлээ. Төрийн

байгууллагуудын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд дээрх журмын хэрэгжилтийг хангах, энэ талаар сургалт, сурталчилгаа хийх арга хэмжээг тусгуулан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны хуралдаанаар “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалтаар хангах асуудлыг хэлэлцүүлсэн бөгөөд хуралдаанаар дээрх журмыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл манлайлан хэрэгжүүлэхээр, аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг дарга нар хяналт хэрэгжүүлэгч иргэнийг шалгаруулж ажиллуулахаар, Авлигатай тэмцэх газар үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйгээр ханган, үр дүнг тооцож ажиллахаар шийдвэрлэв.

“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэгч байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, харилцан туршлага солилцох боломж бүрдүүлэх зорилготой “Олон нийтийн хяналт хэрэгжүүлэхэд төрийн байгууллагаас дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 20 аймгийн ИТХ-ын Ажлын албаны болон Засаг даргын Тамгын газрын 39 албан хаагчийг хамрууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.4.4.1-т тусгагдсан “Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гомдол хүлээн авч хянан шалгах, шийдвэрлэх ажиллагааны чанарын үзүүлэлтийг сайжруулах” арга хэмжээний хүрээнд 2024 онд хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл гомдлын мэдээлэлд тоон болон чанарын судалгаа, дүн шинжилгээний ажлыг “Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ-аар гүйцэтгүүлсэн бөгөөд ажлын тайлан, зөвлөмжийг хүлээн аваад байна. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр: Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын гишүүдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтыг Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын гишүүд 35 хүнийг хамруулан, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс, “Глоб Интернэшнл төв” ТББ-тай хамтран “Мэдээллийн хүртээмжийн тэлэлт ба төрийн үйл ажиллагаанд оролцох нь” сэдэвт хэлэлцүүлгийг төрийн болон иргэний нийгэм, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, сэтгүүлчдийг хамруулан зохион байгууллаа.

Хөтөлбөрийн 4 дүгээр зорилго буюу хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлэх хүрээнд ISO 37001, ISO/IEC 17021-9, ISO/IEC 17021-13 стандартыг монгол хэлнээ орчуулж, төрийн өмчит 7 компанид нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу ISO 37001 стандартыг төрийн өмчит хуулийн этгээдүүдэд нэвтрүүлэх чиглэлээр Шадар сайдын ажлын албатай хамтран ажиллах төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж байна.

“ISO 37001 Авлигын эсрэг тогтолцоо”-ны тухай ерөнхий ойлголт, мэдлэг олгох сургалтыг төрийн өмчит 8 компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг оролцуулан зохион байгууллаа.

Ази-Номхон далайн бүсийн орнуудын итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (Asia Pacific Accreditation Cooperation)-ын Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт нэгдсэн хүрээг “ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоо” стандарт болон “ISO 37301 Нийцлийн менежментийн тогтолцоо” стандартын баталгаажуулалтын төрлөөр өргөтгөх ажлыг зохион байгуулах саналыг Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлэв.

Хөтөлбөрийн 5.3 дугаар зорилт буюу шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар иргэдийн итгэл хүлээсэн шүүхийн тогтолцоог бэхжүүлэх хүрээнд судалгаанд суурилсан тодорхой ажил, арга хэмжээний саналыг Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороонд хүргүүлэв. 5.3.3-т заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, прокурор, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Үндэсний статистикийн хорооны эрх бүхий албан тушаалтнуудтай уулзаж, харилцан мэдээлэл солилцлоо.

Авлига, албан тушаалын гэмт хэрэг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх агуулга, хөтөлбөрийг шүүгчийн давтан сургалтад нэвтрүүлэх талаар сургалтын хөтөлбөрийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран боловсруулж, Шүүхийн сургалтын хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн батлуулав.

Прокурорын байгууллагын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хараат бус байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Авлига, мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 20 прокурор, Авлигатай тэмцэх газрын 30 мөрдөгчийг хамруулан зохион байгууллаа.

Хөтөлбөрийн 5.3.1-д заасан арга хэмжээний хүрээнд “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлын тухай ойлголт ба шүүгчийн хариуцлагатай байдлыг бэхжүүлэх арга хэмжээний талаарх санал” сэдэвт судалгааг хийж, шүүгчийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилготой 4 арга хэмжээг томьёолон шүүхийн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллав. “Авлига, албан тушаалын гэмт хэрэг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх агуулга, хөтөлбөрийг шүүгчийн давтан сургалтад нэвтрүүлэх талаар сургалтын хөтөлбөрийг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран боловсруулж, Шүүхийн сургалтын хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн батлуулав. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаалаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, шүүгч нарт зориулсан авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, хэрэг, зөрчлийг шийдвэрлэж буй олон улсын туршлага, практик үйл ажиллагааны талаарх мэдлэг олгох, мэргэшүүлэх бүсчилсэн сургалтыг зохион байгуулав.

Хөтөлбөрийн 6 дугаар зорилгын хүрээнд Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах асуудлыг Авлигатай тэмцэх үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлээ.

Хөтөлбөрийн 7 дугаар зорилго буюу төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааны эрсдэлийг бууруулах хүрээнд Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эдийн засаг хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Соёлын яам, Эрчим хүчний яам зэрэг 11 яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хөрөнгө оруулалт хөгжлийн газар зэрэг 6 агентлаг, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг болон Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Сэлэнгэ, Говь-Алтай, Баянхонгор, Ховд, Баян-Өлгий зэрэг 9 аймаг, “Биокомбинат” ТӨХХК, “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК зэрэг төрийн өмчит 5 компани буюу нийт 39 байгууллагын 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийж авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээ, мэдээллээр хангах ажлыг зохион байгууллаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй хамтран “Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт, хяналтыг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам зэрэг байгууллагын төлөөллийг оролцуулж төсөв, хөгжлийн бодлогын уялдааг хангах, төлөвлөлт, тайлагналт, хяналтыг хэрэгжүүлэх, дотоод аудитыг сайжруулах арга зам, өнөөгийн түвшин, цаашид анхаарах асуудлаар хэлэлцэж, төсвийг зөв төлөвлөж, үр дүнтэй зарцуулах сайн туршлага, шийдлийг тодорхойлов. Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтэд үндэслэсэн зөвлөмжийг холбогдох 16 яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт хүргүүлэв. Тогтоолын хэрэгжилтэд улирал тутам хяналт тавин ажиллаж байна.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газартай хамтран төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явцын ил тод байдалд хяналт тавьж, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд дүн шинжилгээ хийлээ.

Худалдан авах ажиллагаанд оролцогч, ажлын гүйцэтгэл хангалтгүй, хариуцлагагүй аж ахуйн нэгжүүдийн талаар “Ажлын гүйцэтгэлийн түүх” үүсгэж тендерт өрсөлдөх байдлын шалгуур үзүүлэлтэд оруулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим санд “Ажлын түүх” үүсгэх цонх бүхий цэсийг бий болгох, зарим аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхийн хязгаарлах бүртгэлд хамруулах зэргээр Сангийн яам, Худалдан авах ажиллагааны газартай хамтран ажиллаж байна.

Хөтөлбөрийн Зорилт 7.3-т зааснаар Засгийн газрын өр, тусгай сан, гадаадын зээл, тусламжийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Эрүүл мэндийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Улсын нөөцийн газарт ажиллаж, сангийн бүрэлдэхүүн, томилгоо, чиг үүрэг, зохион байгуулдаг арга хэмжээ, сангийн үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн актууд, тус сангаас олгодог эргэн төлөх нөхцөлгүй санхүүжилт, эргэн төлөгдөх нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлийн талаар танилцан ил тод байдлыг хангах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр Эрүүл мэндийн сайд, Соёлын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газарт зөвлөмж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тогтоогдсон нөхцөл байдлын талаарх мэдээллийг хүргүүлээ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Сангийн яам, Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эдийн засаг хөгжлийн яам, Барилга хот байгуулалт, орон сууцжуулалтын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Эрчим хүчний яам, Ашигт малтмал газрын тосны газар, Онцгой байдлын ерөнхий газар, Биеийн тамир спортын хороо, Орхон, Дундговь, Хөвсгөл аймаг зэрэг нийт 15 салбар, байгууллагын худалдан авах ажиллагаанд сүүлийн 3 жилийн хугацаанд оролцсон боловч чанаргүй ажил гүйцэтгэсэн аж ахуйн нэгж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, зарим аж ахуйн нэгжийн тендерт оролцох эрхээ хязгаарлуулах этгээдийн бүртгэлд хамруулахаар Сангийн яаманд, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудлыг шалгуулахаар холбогдох хэлтэст мэдээллийг шилжүүлэв.

Гадаадын зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн [www.odamis.mof.gov.mn](http://www.odamis.mof.gov.mn) цахим системийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор бүтээн байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа 527 төсөл, арга хэмжээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн холбогдох ажилтнууд үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн талаар болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, тендер сонгон шалгаруулалтаар ажил гүйцэтгэсэн ажлын түүх үүсгэх ажлыг хэлэлцэх зорилгоор Сангийн яам, Худалдан авах ажиллагааны газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон холбогдох яам, агентлагийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал дүгнэлтэд тулгуурлан, Сангийн сайдад зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллав.

Авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор байгаль орчин, аялал жуулчлал, хот байгуулалт, эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авав. Тухайлбал,

- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж байгаа Азийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэж буй “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-ийн холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар холбогдох хэлтэст мэдээллийг шилжүүлэв.
- Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн 11 төсөл, хөтөлбөрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрчим хүчний салбарын хэмжээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удаашралтай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн шалтгаан, нөхцөлийг арилган үр дүнг нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд мэргэжлийн шаардлага хангасан мэргэжилтнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар ажиллуулах талаар зөвлөмж хүргүүлэв.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” 40.0 сая ам.долларын төслийн зарцуулалтын ил тод байдалтай танилцан, дүн шинжилгээ хийж, төслийн нэгжийн ажилтнуудыг томилох ажиллагааг ил тод болгох арга хэмжээ авах талаар зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулав.

Хөтөлбөрийн 8 дугаар зорилго буюу төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын цалин хөлс, урамшууллын дүнг нээлттэй, ил тод болгох, иргэд олон нийт танилцах, хяналт тавих боломжийг

бүрдүүлэх асуудлыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Цемент шохой” ХХК, “АЗЗА нэгдэл”, Барилгын хөгжлийн төв зэрэг төрийн өмчит хуулийн этгээдүүдийн гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийж, тус тогтоолын хэрэгжилтийг хангах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, хяналт тавин ажиллаж байна.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022, 2023 оны санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, хөрөнгийн хөдөлгөөний тайланд дүн шинжилгээ хийж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэв.

Хөтөлбөрийн зорилт 9.2 буюу олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээх хүрээнд салбар бүрийн оролцоог хангасан 2-оос доошгүй контент бүтээх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, эрүүл мэнд, байгаль орчин, боловсрол, хөдөлмөр нийгмийн хамгаалал, зам тээвэр, соёл, спорт, эрчим хүч, гадаад харилцаа, гааль татвар, уул уурхай, нийслэл, дүүрэг зэрэг 23 байгууллагын үйл ажиллагааны онцлог, төрийн үйлчилгээний хүнд суртал чирэгдлийг бууруулах, ил тод байдлыг сайжруулах, шүгэл үлээх болон авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах агуулгатай, бодит кейс, жишээн дээр тулгуурлан нийт 51 контент (шторк, рийлс, видео гэх мэт)-ыг бүтээж олон нийтийн хүртээл болголоо.

Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2020 онд хүүхдийн зохиолч Н.Мандалын зохиолоор Хүүхэлдэйн театрт хамтран найруулагч М.Ариунтуяагийн найруулснаар “Хаалган хадны нууц” нэртэй хүүхэлдэйн оролцоот хүүхдийн жүжгийг мэргэжлийн түвшинд тайзны бүтээл болгон туурвиж, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр зорилтот бүлгийн 250 хүүхэд, 2024-2025 оны хичээлийн шинэ жилийг угтаж ерөнхий боловсролын 12, 23, 24, 32, 45, 84 дүгээр сургуулийн 1-5 дугаар ангийн 451 сурагч, ерөнхий боловсролын 108, 149, 22, 133, 40 дүгээр сургуулийн 2-5 дугаар ангийн 453 сурагч, нийт 1154 хүүхэдэд үзүүлэв. Энэхүү арга хэмжээ нь хүүхэд, багачуудын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар буюу жүжгээр дамжуулан тэдэнд шударга ёсны үзэл хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ боллоо.

Хүүхэлдэйн театр, “Цахим сэтгүүл зүйн мэдээ” НҮТББ-тай хамтран жүжгийн бичлэгийг мэргэжлийн түвшинд хийж, байгууллагын санд хадгалуулав. Энэхүү жүжиг Соёлын яамны “Хүүхэдэд урлагаар дамжуулан заавал үзүүлэх жүжгийн жагсаалт”-д тусгагдахаар болов.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэх арга зүйг боловсруулах ажлыг ШУА-ын Философийн хүрээлэнтэй хамтран гүйцэтгэлээ.

Хөтөлбөрийн Зорилт 9.3.1 буюу ёс суртахуун, хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрийг олон улсын туршлагад тулгуурлан шинэчлэлт, үнэлгээ хийж хэвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Боловсролын яамтай хамтран нийслэлийн 8, орон нутгийн 8, нийт 16 ерөнхий боловсролын дунд сургуульд “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг зохион байгуулан дэмжиж ажиллав.

Хөтөлбөрийн 9.3.2.1-д заасан “Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн оюутнуудад чиглэсэн сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах”, 9.4.4.1-д заасан “Боловсролын сургалтын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээг зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимтэй хамтран ахисан түвшний сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх ажлыг гүйцэтгэж байна.

Хөтөлбөрийн 9.3.3.1-д заасан арга хэмжээний буюу “Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” хүрээнд иргэний нийгмийн болон төрийн бус байгууллага, холбоодын судалгааг гаргаж, нийт 34 төрийн бус байгууллагатай уулзалт хийж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр контент бүтээх, сургалт өдөрлөг зохион байгуулах, сургагч багшаар бэлтгэх, сурталчилгааны материал түгээх, контентуудыг өөрсдийн сувгаар сурталчлах зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүллээ.

Хөтөлбөрийн Зорилт 9.4 буюу “Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.” зорилтыг хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шударга зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Шударга байх хамгийн гоё” сургалт, өдөрлөгийг 3 удаа зохион байгуулж, нийт 278 сурагчийг, шударга ёсны талаар сурагчдад сайн үлгэр дуурайлал үзүүлэх “Сайн иргэн” аяныг зохион байгуулж, нийслэлийн ерөнхий боловсролын 50 сургуулиас 6123 сурагчийг сургалтад хамруулав. Мөн Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан “Хичээлээс гадуурх үйл ажиллагааг сурталчлан таниулах өдөрлөг”-т хамрагдсан 250 сурагчид “Сайн иргэн” аяны талаар болон “Шударга ёсны боловсрол” сэдвээр мэдээлэл хийлээ.

Монголын Зохиолчдын эвлэлийн шагналт зохиолч, яруу найрагч Д.Энхболдбаатарын авлигын хор хөнөөл, үр дагавар нэгэн гэр бүлийн амьдралд хэрхэн хүндээр тусч байгааг илэрхийлсэн “Төлөөс” жүжгийн зохиолын бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэн авч, Оюуны өмчийн газраас гэрчилгээг хүлээн авлаа.

Төрийн өмчийн 7, төрийн бус өмчийн 17, нийт 24 их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн ёс зүйн агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгасан эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг Боловсролын яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

### **Дөрөв. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:**

4.1. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Олон улсын авлигын эсрэг өдрийг тохиолдуулан “Авлигын эсрэг нэгдье” арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, Ажлын албаны албан хаагч, Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагын албан хаагч, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 700 гаруй албан тушаалтныг хамруулан 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр зохион байгууллаа.

Төрийн байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх ажлыг зохион байгуулав. Төлөвлөгөөг хэрэгжүүлбэл зохих төрийн захиргааны нийт 90 байгууллагын өөрсдийн дундаж үнэлгээ 96 хувь, Авлигатай тэмцэх газраас хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр 59 хувь буюу үр дүн хангалтгүй үнэлэгдэж байсан бөгөөд 2024 онд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт хийхдээ нийтлэг байдлаар хэрэгжүүлбэл зохих 3 зорилт, 12 арга хэмжээг санал болгон хүргүүлж, төрийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллав.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланд хяналт шинжилгээ хийлээ. Үнэлгээгээр төлөвлөгөөний хэрэгжилт 65.0 хувьтай үнэлэгдсэнийг 2023 оны мөн үетэй харьцуулбал, хэрэгжилт 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2024 оны жилийн эцсийн тайланг үнэлэх ажил 2025 оны I улиралд хийгдэнэ.

Авлигын эсрэг олон улсын өдрийг тохиолдуулан аймаг, сум, нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид болон нийтийн албан тушаалтнуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг танилцуулах, сурталчлах, авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор авлига, ашиг сонирхлын зөрчлийн урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Тус арга хэмжээний үеэр нийслэлд 700 хүн, 21 аймагт 9858 хүн, нийт 10558 хүнийг сургалтад хамруулж чадавхжуулсан байна.

Нийгмийн амьдралд оюутан залуусын бодит оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг өрнүүлэх, дэмжиж хамтран ажиллах замаар шударга, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх зорилгоор “Түлхүүр” уралдааныг зохион байгууллаа. Тус тэмцээнд 25 багийн 125 оюутан залуус өрсөлдсөнөөс Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн “Гарц” баг нэгдүгээр байранд, “Их засаг” их сургуулийн “Rolex” баг хоёрдугаар байранд, “Их засаг” их сургуулийн “Victory” баг болон “Шихихутуг” их сургуулийн “Алтан гэрэгэ” багууд гуравдугаар байранд, тусгай байрт “Их засаг” их сургуулийн “Reverse” баг тус тус шалгарав. Энэхүү тэмцээн нь оюутан залуус үе тэнгийнхэндээ шударга байх, хүнд суртал, авлигыг үл

тэвчихийг уриалсан, тэдний идэвх санаачилгыг өрнүүлсэн тэмцээн болсон бөгөөд авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар бүрэн цогц ойлголттой болж чадавхжсан гэж үзэж байна.

2023 оноос нийслэлийн 1, 12, 24, 32, 40, 84 дүгээр сургууль, Багануур дүүргийн “Боловсрол” цогцолбор сургууль, Хэнтий аймгийн “Бор-Өндөр” цогцолбор сургууль, “Тэмүүжин цогцолбор” сургууль, “Хэрлэн” 1, 2 дугаар сургуульд байгуулсан “Шударга ёсны клуб”-ын үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт, сурталчилгаа хийх ажлыг хамтран зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр клубын үйл ажиллагааг сурталчлах, клуб хооронд туршлага солилцуулах арга хэмжээг 3 удаа зохион байгуулав. Энэхүү уулзалтад клубыг хариуцан ажиллуулж байгаа 8 сургуулийн захирал оролцож, үйл ажиллагаагаа танилцуулж, харилцан туршлага солилцов.

Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн “Шударга ёсны клуб”-ын үйл ажиллагааны 2024 оны жишиг төлөвлөгөөг хүргүүлсэн бөгөөд 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, хангалтгүй үнэлэгдсэн ажил арга хэмжээний хэрэгжилтийг хангах, үр дүнг дээшлүүлэх талаар зөвлөгөө өгч, клуб хоорондын туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан. 2024 оны жилийн эцсийн тайланг үнэлэх ажлыг 2025 оны I улиралд гүйцэтгэнэ.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуульд “Шударга ёсны клуб” байгуулахад дэмжлэг үзүүлж клубын нээлтийг хийлээ.

4.2. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх” чиг үүргийн хүрээнд:

“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилт 2023, 2024 оны хагас жилийн байдлаар хангалтгүй байсантай холбогдуулан журмыг хэрэгжүүлэгч байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах ажил арга хэмжээг төлөвлөх, өнөөгийн нөхцөл байдал, учирч буй хүндрэл бэрхшээлийг тогтоох, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор 21 аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нараас авсан судалгааны дүнд үндэслэн “Олон нийтийн хяналт хэрэгжүүлэхэд төрийн байгууллагаас дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургалтад 20 аймгийн ИТХ-ын Ажлын албаны болон Засаг даргын Тамгын газрын 39 албан хаагчийг хамрууллаа.

4.3. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх хэсэгт заасан “төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах” чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллаж байна.

Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төвөөс хамтран зохион байгуулсан “Өмгөөлөгч-Танд тусалъя 2023” иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөгт хамтран оролцож, иргэдэд авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, гомдол, мэдээлэл гаргах журам болон холбогдох бусад асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгсний дээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмгөөлөгчдөөр дамжуулан авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг хамтран зохион байгуулах чиглэлээр уулзалт хийлээ.

“Иргэд төсвөө хянан” иргэний нийгмийн сүлжээний ТББ-тай хамтран “Нээлттэй нийгэм форум”-ын дэмжлэгтэйгээр “Орон нутаг дахь төсвийн үйл явцын мониторинг” төслийн хэлэлцүүлэгт “Төсвийн төлөвлөлт, хяналт, дэд бүтцийн салбарын авлигын эрсдэл” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

Эрчим хүчний салбарт авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Монголын эрчим хүчний салбарын барилга, засварчдын холбоо” ТББ-тай хамтран “Эрчим хүчний салбар дахь авлигын эрсдэл-иргэний нийгмийн байгууллагын оролцоо” сургалт, уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалт, уулзалтад “Монголын эрчим хүчний инженерүүдийн холбоо” ТББ, “Монголын турбинчдын холбоо” ТББ, “Эрчим хүчний хөгжлийн төлөө

Монголын нийгэмлэг” ТББ, “Эрчим хүч, инноваци технологийн төв” ТББ, “Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөл” ТББ зэрэг төрийн бус байгууллагын төлөөлөл оролцоо.

“Монгол бичгийн нийгэмлэг” НҮТББ-тай хамтран уламжлалт монгол бичгээр хэвлэгддэг “Уламжлал” сэтгүүлийн II, III, IV улирлын дугаарт “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл”, Хүүхэлдэйн театрт хамтран бүтээсэн “Хаалган хадны нууц” хүүхэлдэйн оролцоот хүүхдийн жүжиг болон ерөнхий боловсролын 12 сургуулийн “Шударга ёсны клуб”-ын үйл ажиллагааны талаарх мэдээллийг нийтлүүлээ.

Төрийн байгууллага, нийтийн албан тушаалтны хүнд суртал, албан хаагчийн ёс зүйн талаар мэдээлэх, төрийн үйлчилгээнд мониторинг хийх зорилготой “Товш” аппликэйшнийг “И Монгол академи” УТҮГ-ын тусламжтайгаар хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд бүрэн нэвтрүүлээд байна.

4.4. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дахь хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд:

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны "Заавар батлах тухай" А/183 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар"-ын дагуу нийт 17 салбарт хамаарах 68 шийдвэр, дүрэм, журмыг хянаж, 19 дүрэм, журмыг бүхэлд нь хүчингүй болгох тухай, 16 актыг хуульд заасан шаардлага хангуулах саналыг хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Хүргүүлсэн саналын дагуу 7 шийдвэрийг хүчингүй болгож, 1 шийдвэрт өөрчлөлт оруулан хуульд нийцүүлэх арга хэмжээ авсан байна.

4.5. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

Радиоогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, иргэдийн оролцоог хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээллийг хүргэх зорилгоор “Дэлхийн монголчуудын радио-MGL” радиотой хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг танин мэдүүлэх чиглэлээр “Нэг дусал” контентыг нэг удаад 3 минут үргэлжлэхээр бэлтгэн өдөрт 9 удаагийн давталтайгаар сонсогчдод хүргэж байна. Тайлант хугацаанд 240 сэдвээр цуврал контент бэлтгэн хүргэсэн байна.

Сувгийн тоог нэмэгдүүлэх хүрээнд “Зохист аялгуу 89.7”, “Авто радио 96.3” радиотой хамтран авлигын эсрэг сурталчилгааны контент, байгууллагын онцлох контентыг түгээх ажлыг эхлүүлээд байна. Энэ хүрээнд “Авто радио 96.3” радиогоор “Авлигатай тэмцэх газрын цаг” тусгай нэвтрүүлгийг нэвтрүүлэхээр санаачилснаар тус нэвтрүүлэгт 14 ажилтан оролцож, байгууллагын үйл ажиллагааг танилцуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээллийг олон нийтийн хүртээл болгож байна.

МҮОНТ-тэй хамтран 14 хоног тутамд “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” нэвтрүүлгийг 20 минутаар бэлтгэн тогтсон цагт олон нийтийн хүртээл болгож байна. Тайлант хугацаанд 23 удаагийн дугаарыг тодорхой сэдвээр бэлтгэн МҮОНТ төдийгүй Малчин, Лайв телевизээр болон байгууллагын фэйсбүүк, пейж хуудсаар нэвтрүүлсэн.

“Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын үйл ажиллагааны онцлог”, “Авлигын гэмт хэргүүд болон олон улсын судалгаанд хийсэн дүн шинжилгээ”, “Үйлийн үр байдаг гэдэгт би итгэдэг”, “УИХ-ын 2024 оны сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигч, сонгогчдын анхаарах асуудал”, “Төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн анхаарах асуудал”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг судалгааны ажлуудыг хэрхэн хийдэг вэ?”, “Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын онцлог”, “110 тусгай дугаарт ирж буй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт”, “Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн”, “Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлсэн онцлог ажлууд” сэдвээр 11 подкастыг бүтээж, олон нийтийн хүртээл болголоо.



Авлигын хор хөнөөлийг таниулах, шударга зан суртахуунд иргэд, олон нийт, төрийн албан хаагчдыг уриалах, авлигын эсрэг үйл ажиллагаанд тэднийг татан оролцуулах зорилгоор зорилтот бүлгүүдэд зориулсан видео контентуудыг цахим хуудас, пэйжээр болон телевизүүдтэй хамтран түгээх ажлыг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд сурталчилгааны дэлгэц болон фэйсбүүкээр 57 баннер, 20 постер, 27 рийлс, 25 шторк, контент бэлтгэн түгээж, гудамж талбай, үйлчилгээний газар, олон нийтийн газарт байршуулснаас гадна нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулав.

2024 онд авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран 286 удаагийн сургалт (цахим, танхимаар)-ыг зохион байгуулж, 36866 хүнийг хамруулснаас төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 272 удаагийн сургалтад 35738, хувийн хэвшлийн байгууллагад зориулсан 6 удаагийн сургалтад 717, оюутан, залуус, иргэдэд зориулсан 8 удаагийн сургалтад 411 хүнийг тус тус хамруулсан байна. Үүнээс сургалтыг тодорхой салбарын албан хаагчдыг чадавхжуулахад чиглүүлэн зохион байгуулахад анхаарч ажилласнаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 474 ажилтныг 4 удаагийн, дүүргийн 1187 хэсгийн ахлагчийг 4 удаагийн, сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуулийн, үүнээс аймаг, сумдын 1693 удирдах ажилтанд зориулсан 7 удаагийн (цахим), нийслэлийн 9 дүүргийн 461 удирдах ажилтанд зориулсан 8 удаагийн цуврал (танхим) сургалтыг тус тус зохион байгуулав.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө орлогын мэдүүлэг, түүнийг хянах шалгах ажиллагаа, авлигын гэмт хэрэг, түүнд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сургалт, сурталчилгааны чиглэлээр хамтран ажиллах зорилгоор хэвлэл мэдээллийн 23 байгууллагын төлөөллийг оролцуулан 2 удаагийн, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн удирдах 25 албан тушаалтныг хамруулан сургалт, уулзалт зохион байгуулсан нь үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багш бэлтгэж үйл ажиллагаандаа татан оролцуулах хүрээнд Төрийн албаны зөвлөл, Батлан хамгаалах яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Соёл, урлагийн газар, “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК, “Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Ховд дулааны станц” ТӨХК, “Биокомбинат” ТӨХК, “Монголын Байгаль орчны иргэний зөвлөл” ТББ, “Нийгмийн ажилтны сургалт, хөгжил манлайллын төв” ТББ, “Монголын авто замчдын холбоо” ТББ зэрэг нийт 36 байгууллагын 42 албан хаагчийг сургагч багшийн сургалтад хамруулж, гэрчилгээ олгов.

Сургагч багш нарт дэмжлэг үзүүлэх, туршлага солилцох зорилгоор уулзалтыг зохион байгуулж, 20 байгууллагын 29 сургагч багш оролцуулснаар багш нар өөрсдийн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээний талаарх мэдлэг, туршлагыг танилцуулж, харилцан мэдээлэл солилцлоо.

Тайлант хугацаанд “Авлигын эсрэг үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоо”, “УИХ-ын гишүүн танаа”, “ИТХ-ын төлөөлөгч танаа” гарын авлагыг хэвлүүлж олны хүртээл болгосны дээр МУИС, Шинжлэх ухааны сургуультай хамтран “Мэргэжлийн ёс зүйн” хичээлийн сургалтын гарын авлагыг боловсруулаад байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд сурталчилгааны материалыг бүхий л төрлөөр хэвлэн, түгээх ажлыг тасралтгүй зохион байгууллаа. Үүнд “Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо” ТББ-тай хамтран харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан сурталчилгааны материал (4000ш), 2024 оны календарь (300ш), “Улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавих хориглолт, хязгаарлалт”, “Боломжоо булаалгахгүй”, “Худалч хамар”, “Авлигагүй ирээдүйн төлөө”, “Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт” зурагт хуудас (2850ш), “Авлигын эсрэг Нэгдье 110” дүрслэл бүхий дэвтэр (3000ш); “Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт” нугалбар (42000ш)-ийг тус тус хэвлүүлж түгээлээ.

Хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, нийт 7 нэвтрүүлэг, 1 ярилцлагыг олон нийтэд хүргэлээ. Тухайлбал, “ТВ-5” телевизийн “Харандааны адал явдал” хүүхдүүдэд зориулсан нэвтрүүлгээр байгууллагаас санаачлан хэвлүүлсэн “Сургамжит үлгэр” номыг сурталчлан таниулах 4 удаагийн нэвтрүүлэг хийж, 16 удаагийн давтамжтайгаар түгээж, Монгол HD телевизийн “Терминал”, МҮОНТ-ийн “Зочны цаг” нэвтрүүлэгт зочноор оролцож цаг үеийн болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний талаар ярилцлага өгөв. “Вип 76” экспертийн сэтгүүлд ярилцлага нийтлүүлсний дээр “Ийгл” телевизийн “Иргэний мэдээ” хөтөлбөртэй 7 хоног бүр хамтран ажиллахаар тохиролцон, 2025 оноос хэрэгжүүлэхээр боллоо.

СУИС-ийн Кино, телевиз, медиа урлагийн сургуультай хамтран “Авлигын эсрэг таны оролцоо” сэдэвт анимэйшн уралдааныг оюутнуудын дунд зохион байгуулж, шалгарууллаа. Шалгарсан 22 анимэйшн бүтээлээр контент хийж түгээхээр ажиллаж байна.

4.6. Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр Сангийн яам, Батлан хамгаалах яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Соёлын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Стандарт, хэмжил зүйн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Ус сувгийн удирдах газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Боловсролын ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Зам тээврийн хөгжлийн төв, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Авто тээврийн үндэсний төв, Говь-Алтай аймгийн ИТХ, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв, 21 аймгийн Засаг дарга, ИТХ, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 9 дүүргийн газар зохион байгуулалтын алба, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК зэрэг давхардсан тоогоор 26 байгууллагад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2023, 2024 онд хүргүүлсэн нийт 25 зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон, хэрэгжилт хангалтгүй байгаа байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийх, зөвлөмжийн үр дүнг дээшлүүлэх талаар зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлэх зэрэг арга хэмжээг авч байна.

Тайлант хугацаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн өмнөх оны 10, 2024 оны 142, нийт 152 мөрдөгчийн мэдэгдлээс 108 мэдэгдлийн мөрөөр ажиллаж шалтгаан, нөхцөлийг арилгах ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт хийх зэргээр арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллав.

6.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т заасны дагуу авлигын эрсдэл, шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, эрсдэлийн түвшнээс хамааран урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг ялгавартай тогтоож, багц арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх хүрээнд:

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын сан, Улсын нөөцийн сан, Кино урлагийг дэмжих сан, Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан, Бүх нийтийн үйлчилгээний сан, Эрүүл мэндийг дэмжих сан, Цэргийн төв эмнэлэг, Хан-Уул дүүргийн “Мөнхбадрах” өрхийн эрүүл мэндийн төв, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл, Монгол-Кувейтийн байгаль хамгаалах төв зэрэг нийт 14 байгууллагад ажиллаж, 7 байгууллагад авлига, хүнд суртлаас урьдчилан сэргийлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөмж, 2 байгууллагад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар шаардлага хүргүүлэв.

Дээрх байгууллагад ажиллах хугацаанд тогтоогдсон авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэлтэй нөхцөл байдлын талаар эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулах, түүнээс урьдчилан

сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох зорилгоор 6 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тухайлбал,

- “Нийтийн эзэмшлийн зам талбайд ашиглагдаж буй тусгай зориулалтын бодис: Авлигын эрсдэл, хор уршиг, хүний эрүүл мэнд” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэв. Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт зөвлөмж хүргүүлснээр тухайн бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт, зам талбайг цэвэрлэх аргачлал, стандартыг батлуулах ажлууд хийгдэж, нийлүүлэлт буюу худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлээд байгаа талаар хариу ирүүлээд байна.
- MNS 7023:2023 “Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага” бүхий “Мэдээллийн самбарын стандарт” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, Сангийн сайдад тус тус зөвлөмж хүргүүлэв. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны I улиралд дүгнэнэ.
- “Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчин, хэрэгцээ шаардлага, нөхцөл байдал, түүнийг өөрчлөх боломж, олон улсын сайн туршлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хуулийн төсөлд үндэсний аюулгүй байдалд хамаарах асуудлаар шүгэл үлээсэн үед хамгаалах зохицуулалт, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага, шүгэл үлээгчийг хамгаалах хараат бус нэгжтэй байх зэрэг асуудлаар хэлэлцэв. Хэлэлцүүлэгт Хүний эрхийн үндэсний комисс, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Монголын хуульчдын холбоо болон Монголын өмгөөлөгчдийн холбооны 30 гаруй төлөөлөл оролцов.
- “Санхүү, татвар, гаалийн байгууллагын цахимжуулалт, түүний үр нөлөө ба иргэн, хуулийн этгээдтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн гүйцэтгэл 97.5 хувь байгаа бөгөөд хэлэлцүүлэг үр дүнтэй боллоо.
- “Мэргэжлийн ёс зүйн боловсрол, тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын газартай хамтран төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулийн 26 албан тушаалтныг хамруулан зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн “Мэргэжлийн ёс зүй” хичээлийн сургалтын гарын авлагын эхийг МУИС-ийн мэргэжлийн багтай хамтран боловсруулаад байна.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар нь “Шударга байдлын үнэлгээ”-ний 2023 оны дүнгээр хамгийн бага буюу 70.3 хувиар үнэлэгдсэн тул 2024 онд уг үнэлгээг сайжруулах зорилгоор тус дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бид авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аяныг 1 сарын хугацаатай зохион байгуулав. Аяны хүрээнд Засаг даргын Тамгын газрын харьяа байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан өдөрлөг зохион байгуулж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар 500 иргэнээс санал асуулгыг авч, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэв. Аяны хүрээнд 3 удаагийн сургалт зохион байгуулж, 180 албан хаагчийг хамруулсны зэрэгцээ албан хаагчдын дунд авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор хэлэлцүүлэг тэмцээн, илтгэлийн уралдааныг зохион байгууллаа.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газартай хамтран нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж, өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэхэд гарч буй зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж хүргүүлж, авлигын эсрэг төлөвлөгөөг батлан хэрэгжүүлснээр амжилттай хэрэгжиж, гүйцэтгэл 90 хувьтай байна.

Сургууль, цэцэрлэгийн элсэлтийн бүртгэлийн үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүсэж болзошгүй авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор сургууль, цэцэрлэгүүдэд ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр ханган, дэмжлэг үзүүлж ажиллалаа.

#### **Тав. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр:**

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүрэг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын болон зорилтот судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2024 оны байдлаар:

- “Шударга байдлын үнэлгээний судалгааны мэдээлэл цуглуулах, тайланг бэлтгэж, үр дүнг олон нийтэд мэдээлэх” ажлыг зохион байгуулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Бодлогын шийдэл” ХХК-тай гэрээг байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллалаа. Судалгаанд төрийн 16 яам, 34 агентлаг, 21 аймгийн болон нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийт 81 байгууллага хамрагдсан бөгөөд үнэлгээний 2024 оны дундаж 72.6 оноотой гарч, өмнөх оноос 4.0 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

“Шударга байдлын үнэлгээ”-гээр доогуур үнэлэгдсэн байгууллагуудын үзүүлэлтүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийж, тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г зохион байгуулав. Судалгааны ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Максима” ХХК-ийн судалгааны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж хамтран ажиллалаа. Судалгаагаар улс төрийн хүрээнд дэх авлигын төсөөллийн индекс 4.05 гарсан бөгөөд өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.09 пунктээр өссөн байна. Сүүлийн 5 жилийн индексийн дундаж үзүүлэлт 4.00 байна. Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын төсөөллийн индекс 3.84 гарсан. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 0.06 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

- “Хүүхдийн шударга байдлын үнэлгээ” 2024 оны судалгааг 21 аймаг, нийслэлийн төрийн өмчийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн 6670 сурагч, 789 багш, албан хаагч, 1293 эцэг, эхийг хамруулан зохион байгууллаа. Судалгааны дүнгээр хүүхдийн шударга байдлын түвшин 2024 онд 4.05 оноотой гарсныг 2023 онтой харьцуулбал 0.08 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Судалгаагаар хүүхдийн насны онцлогт тохирсон шударга ёсыг таниулах, шударга байх талаарх сургалт, сурталчилгааг тогтмол явуулах, сургуулийн орчноос гадна эцэг эхчүүдийн дэмжлэг, хамтын ажиллагааг чухал шаардлагатай байгаа нь харагдаж байна. Цаашид судалгааны үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэх, судалгааны үр дүнд үндэслэн авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

- “Хүүхдийн шударга байдлын судалгаа, ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа”-г Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд үйл ажиллагаанд нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав. Тус судалгааны дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөөд байна.

- Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-тай хамтран “Авлига ба жендер” судалгааг зохион байгуулж, судалгааг хийсэн МУИС-ийн зөвлөх багт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллав. Энэхүү судалгаа нь Монгол Улсад анх удаа хийгдсэн бөгөөд судалгаагаар авлига нь жендертэй тодорхой хамааралтай байна гэсэн үр дүнг гарсан. Судалгааны дүнд үндэслэн хэлэлцүүлгийг хийж, дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэв.

- “Төрийн байгууллагын авлигад өртөж болзошгүй ажлын байрны судалгаа”-г хийж, цаашид мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад нэмэлт оруулах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь чухал гэж үзэв.

- Төрийн байгууллагад авлигын эрсдэлийн үнэлгээ хийж үр дүнг нэгтгэн дүгнэж байгаа өнөөгийн байдлыг судлан, авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэх, үнэлгээ зохион байгуулах талаар зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэлээ.

- Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-тай хамтран зохион байгуулсан “Авлигын эрсдэлийн шинжээч бэлтгэх төсөл”-ийн хүрээнд бэлтгэгдсэн шинжээчдийн багаас Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар болон Авто тээврийн үндэсний төвийн эрсдэлийг үнэлсэн үнэлгээний тайланг хүлээн авч, тайлангийн хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулав.

- Судалгаа, шинжилгээний албанаас 2022-2023 онд гүйцэтгэсэн судалгаа, судалгааны дүнд үндэслэн хийгдсэн ажил, арга хэмжээ, хүрсэн түвшингийн талаарх судалгааг зохион байгуулав. Судалгаагаар мөн хугацаанд хийгдсэн судалгаа зөвлөмж, зөвлөмжийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөн цаашид судалгааны ажлыг зохион байгуулахад анхаарах асуудлуудыг

тодорхойлов. Цаашид судалгааны үр дүнг хэмжиж тооцохтой холбоотой арга зүй, хэрэгжүүлэх процессыг тодорхой болгохоор ажиллаж байна.

- “Төрийн байгууллагаас 2020-2023 онд зарласан худалдан авах ажиллагаан дахь авлигын нөхцөл байдлын судалгаа, мөнгө угаах гэмт хэргийн шалгасан статистик мэдээ болон гэмт хэргийн аюул занал, үйлдлийн арга, типологи хэв шинжийн талаарх судалгаа, Монгол Улс дахь өмч хувьчлал, нийслэлийн газар олголт болон уул уурхайн лиценз олголт, түүнтэй холбогдох судалгаа, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх судалгааг хийсний дээр гадаадад болон Монгол Улсад 2007-2023 онд авлигын чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлын судалгааг хийж, нэгдсэн сан бүрдүүлж, үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүллээ. Мөрдөн шалгах үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөний талаарх судалгаа үргэлжилж байна.

Байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд холбогдох үндсэн үзүүлэлтүүд, тоон мэдээллийг нэгтгэж, “Шударга ёс” онол, арга зүйн цуврал сэтгүүлийн 2024 оны 2 дугаарыг хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгов.

Гадаад улс орон дахь авлигын нөхцөл байдал, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаарх мэдээг 7 хоног тутамд албан хаагчдад хүргүүлж мэдээ, мэдээллээр хангах ажлыг тогтмолжуулснаар тайлант хугацаанд 53 нийтлэл, мэдээллийг хүргүүлж, байгууллагын болон мэдээллийн бусад цахим хуудсанд нийтэлж, олон нийт танилцах, мэдээлэл авах боломжийг бүрдүүллээ.

### **Зургаа. Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:**

6.1. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн мэдээг гаргалаа.


ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2023 оны 2 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 127 байгууллагын 50258 (цахим-47158, хэвлэмэл байдлаар-3100) мэдүүлэг гаргагч мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлж баталгаажуулсан. 1 албан тушаалтан хуулийн хугацаа хожимдуулж мэдүүлгээ мэдүүлсэн тул хуульд зааснаар томилох эрх бүхий албан тушаалтан түүнд сахилгын шийтгэл ногдуулсан.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон түүнтэй адилтгах 347 албан тушаалтнаас 337 албан тушаалтан хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн байна. (10 албан тушаалын орон тоо сул байсан.)

2023 онд УИХ, Засгийн газрын шийдвэрээр төрийн тусгай болон төрийн захиргааны албан хаагчийн ангилал зэрэглэлийг шинэчлэн тогтоосон, Засгийн газрын агентлагууд шинээр байгуулагдаж, зарим агентлагуудын зохион байгуулалтад өөрчлөлтөд орсон, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулсан, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталж, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын арга зүйч мэдүүлэг гаргах болсон зэрэгтэй холбоотойгоор 2023 онд ХАСХОМ-ээ шинэчлэн мэдүүлсэн албан тушаалтны тоо өмнөх оноос 578 нэгжээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


ХАСХОМ-ээ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын 12951 буюу 26.0 хувь нь төрийн захиргааны, 11404 буюу 23 хувь нь төрийн тусгай, 7765 буюу 15.0 хувь нь улс төрийн, 11565 буюу 23.0 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 3317 буюу 6.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдах, төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах 337 буюу 1.0 хувь нь, 2919 буюу 6.0 хувь бусад албан тушаалтнууд эзэлж байна.

**Дүрслэл 1. ХАСХОМ гаргасан албан тушаалтан (төрийн албан тушаалын ангиллаар)**



Нийт мэдүүлэг гаргагчийн 27204 буюу 54.1 хувь нь Улаанбаатар хотод, 23054 буюу 45.9 хувь нь орон нутагт байна. Орон нутгаас Хөвсгөл аймгийн 1488 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлт болж байна.

**Дүрслэл 2. ХАСХОМ мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн тоо (аймгаар)**



Улсын Их Хурлын 2024 оны сонгуульд өрсөлдөхөөр Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нэр дэвшигчдээс цахим системд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах эрх нь үүсгэгдсэн 1577 нэр дэвшигчээс 1433 буюу 90.9 хувь нь мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлж баталгаажуулсан бөгөөд үүнээс 176 нь нийтийн албан тушаалтны хувьд 2023 оны мэдүүлгээ өмнө нь гаргаж мэдүүлсэн байсан бол 1257 нь шинээр мэдүүлэг гаргасан байна. Мэдүүлэг гаргасан нэр дэвшигчдийн лавлагааг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт зааснаар хуулийн хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн. 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэж, 1337 нэр дэвшигчид үнэмлэх олгосон тухай Сонгуулийн ерөнхий хорооны тогтоолыг үндэслэн нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг хуулийн хүрээнд <http://хасхот.iaас.mn/> цахим системд нээлттэй байршуулж, олон нийт танилцах боломжийг олгосон.

Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс үзэхэд 717 албан тушаалтан “Хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 35951 албан тушаалтан “Тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл”, 656 нь “Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан байна.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2023 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.хасхот.iaас.mn> цахим хуудсанд 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нээлттэй байршуулав.

**6.2. Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар.** Мэдүүлгийн хяналт шалгалтыг эрсдэлд суурилан зохион байгуулж, үр дүнг тооцох хүрээнд 2023 онд ХАСХОМ мэдүүлсэн 47158 албан

тушаалтны мэдээлэлд эрсдэл тооцож, дүн шинжилгээ хийхэд Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнууд, Дорнод аймгийн ИТХ, Улсын Их Хурлын Тамгын газар, Нийслэлийн ИТХ, Гаалийн ерөнхий газар, Монгол банк, Баян-Өлгий аймгийн ИТХ, Эрүүл мэндийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дорноговь аймгийн ИТХ, Хөвсгөл аймгийн ИТХ, Гадаад харилцааны яам, Өмнөговь аймгийн ИТХ, Сүхбаатар аймгийн ИТХ зэрэг байгууллагын 7271 албан тушаалтны мэдүүлэг “Дунд” болон түүнээс дээш эрсдэлтэй байлаа.


Иймд эрсдэл өндөр үнэлэгдсэн байгууллагын мэдүүлэг гаргагчдын ХАСХОМ-ийг нарийвчлан шалгуулахаар төлөвлөгөөнд тусгаж, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого нь 1 тэрбум төгрөгөөс дээш нэр бүхий албан тушаалтнуудын мэдээллийг Татварын ерөнхий газарт, зарлага нь орлогоосоо давсан албан тушаалтны мэдээллийг холбогдох хэлтэс, албанд шалгуулахаар шилжүүлж, шийдвэрлүүлэв.

Оффшор бүсэд данс, хөрөнгөтэй, 100 сая төгрөгөөс дээш хөрөнгө, орлого бүртгүүлсэн, хөрөнгийн зарцуулалт нь орлогоосоо давсан, эрсдэл бүхий төрийн өндөр албан тушаалтнуудын судалгааг хийж, үйл ажиллагаанд ашиглаж байна.

**6.3. Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар.** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, гаргаж байгаа нийтлэг зөрчил, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ыг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг дээшлүүлэх, удирдах албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна.

ЭБАТ-ыг мэдээлэл, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор цахимаар нэгдсэн группэд гарын авлага, зөвлөмж, мэдээлэл, зааварчилгаа, сурталчилгааг, бусад цаг үеийн шинжтэй мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж, байнгын холбоотой ажиллаж байна. ЭБАТ-д зориулсан нэгдсэн сургалтыг 12 дугаар сард, шинээр томилогдсон ЭБАТ-ын мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг улирал тутамд зохион байгуулж хэвшлээ. Тайлант хугацаанд 29 удаагийн удаагийн сургалт (цахим, танхимаар)-д нийт 6760, үүнээс 4218 нийтийн албан тушаалтныг, 2542 ЭБАТ, албан тушаалтныг хамруулсан байна.

*Дүрслэл 3. Сургалтад хамруулсан албан тушаалтны тоон үзүүлэлт (2024 оны байдлаар)*




Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор гарын авлагыг эмхэтгэн хэвлүүлээд байна.

Мэдүүлэг гаргагч албан тушаалтан хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаар телевиз, сонин болон цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн бусад хэрэгсэл, нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчилгааг тогтмол хийж мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.

6.4. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн хяналт, шалгалтын ажлын талаар. 2024 онд шинээр хүлээн авсан 204, өмнөх оны үлдэгдэл 101, нийт 305 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгахад 281-ийг хянан шийдвэрлэж, одоо 24 мэдүүлгийг хянах шалгах ажил үргэлжилж байна. Шийдвэрлэлт 92.1 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, шийдвэрлэлтийн хувь 9.5 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд хянан шийдвэрлэсэн 281 мэдүүлгийн 154 буюу 54.8 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 97 буюу 34.5 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр, 30 буюу 10.7 хувийг иргэдээс гаргасан гомдол, мэдээллийн мөрөөр хянан шалгасан байна.

**Дүрслэл 4. Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт (өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал)**



Хяналт шалгалтаар нийт 49 албан тушаалтанд, үүнээс Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар 7 мэдүүлэг гаргагчид сануулах, тус зүйлийн 13.8.2-т зааснаар 24 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.3-т зааснаар 16 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар тодорхой хувиар бууруулах, 1 мэдүүлэг гаргагчид 13.8.4-т зааснаар ажлаас халах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолтыг зөрчсөн 1 албан тушаалтанд мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3-т заасан албан тушаал бууруулах сахилгын хариуцлагыг тооцуулсан байна.

**Хүснэгт 3. ХАСХОМ-ийн хяналт шалгалт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)**

Хамаарах хугацаа	ХАСХОМ					Хариуцлага тооцуулсан
	Өмнөх оны үлдэгдэл	Тайлант хугацаанд хүлээж авсан	Шалгавал зохих	Хянан шийдвэрлэсэн	Ажиллагааны үлдэгдэл	
2023	21	564	585	484 (82.7%)	101 (17.3%)	34
2024	101	204	305	281 (92.2%)	24 (7.8%)	49

Хяналт шалгалтаар 38 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгт холбогдох Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдэл, мэдээллийг шалгуулахаар тус газрын харьяалах хэлтэст шилжүүлсэн. Үүнээс 8 этгээдийг яллагдагчаар татаж, 22 гэмт хэргийн талаарх үйлдэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн байх бөгөөд мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.

Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар 3 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газарт шилжүүлснээр шалгалтаар нийт 2 132 072 560 (хоёр тэрбум нэг зуун гучин хоёр сая далан хоёр мянга таван зуун жар) төгрөгийн татварын зөрчил илэрч, нийт 136 380 970 төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна.



6.5. Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар. 2024 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 828 (өмнөх оны үлдэгдэл 53), нийт 881 гомдол, мэдээллийг хянан шалгахгаас тайлант хугацаанд 817 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 44 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт 92.7 хувьтай байна.

Хянан шалгасан гомдол, мэдээллээс 97 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн холбогдох хэлтэст шилжүүлсэн 88, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 158, бусад хэлтэст шилжүүлсэн 11, хуульд зааснаар хянан үзээгүй болон буцаасан 82, зөрчил илрээгүй 377, бусад 4 байна.

Эрүүл мэндийн яамтай хамтран Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа “Өргөө” амаржих газарт хяналт шалгалт явуулан, шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, “Өргөө” амаржих газрын удирдах албан тушаалтанд зөвлөмж хүргүүлж, зөрчил гаргасан 14 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан бөгөөд хяналт шалгалтын явцад илэрсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг харьяаллын дагуу Цагдаагийн ерөнхий газарт шалгуулахаар шилжүүлсэн байна.


Гомдол, мэдээлэлд дурдсан нөхцөл байдлыг хянан шалгаж, хууль зөрчсөн 44 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хуульд заасан хариуцлага ногдуулсан. Хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулан, ашиг сонирхлын зөрчил үүсэх, эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцөлийг үүсгэж байгаа талаар мэдэгдэж анхааруулан, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн 1 албан тушаалтанд Зөрчлийн тухай хуулийн 15.30 дугаар зүйлд зааснаар торгох шийтгэх оногдуулав.

Зөрчил гаргасан нийтийн албан тушаалтанд сахилгын хариуцлага оногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд уламжилснаар нийт 44 нийтийн албан тушаалтанд хариуцлага ногдуулсан байна. Үүнд:

- Авлигын эсрэг хуулийн 13.8.1-д зааснаар сануулах шийтгэлийг 5 албан тушаалтанд, 13.8.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр бууруулах шийтгэлийг 2 албан тушаалтанд, 33.1.1-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах шийтгэлийг 1 албан тушаалтанд, 33.1.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр бууруулах сахилгын шийтгэлийг 5 албан тушаалтанд;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах шийтгэлийг 26, 29.2.3-т зааснаар албан тушаал бууруулах сахилгын шийтгэлийг 3 албан тушаалтанд, 29.2.4-т зааснаар нийтийн албанаас халах сахилгын шийтгэлийг 2 албан тушаалтанд.

Хянан шийдвэрлэсэн 817 гомдол, мэдээллээс авлигын гэмт хэргийн шинжтэй 81 гомдол, мэдээллийг Мөрдөн шалгах хэлтэст, 7 мэдээллийг Гүйцэтгэх ажлын хэлтэст шилжүүлснээс Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 10, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 4, шүүхэд шилжүүлэх саналтай 7 хэрэг байна. Мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.

*Дүрслэл 5. Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт  
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*



Нийт гомдол, мэдээллийн 87.3 хувийг хуулийн анхны хугацаанд, 13.7 хувийг хуулийн хүрээнд хугацаа сунган шийдвэрлэсэн бөгөөд тайлант үед хугацаа хэтэрсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Тайлант хугацаанд хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 423 буюу 51.7 хувийг Улаанбаатар хотоос, 394 буюу 48.3 хувийг орон нутгаас ирүүлсэн байна. Баян-Өлгий аймгаас 71 буюу 8.7 хувь, Архангай аймгаас 33 буюу 4 хувь, Орхон аймгаас 29 буюу 3.5 хувийг эзэлж байгаа нь бусад аймгаас өндөр үзүүлэлт болж байна.

Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар Сангийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сонгуулийн ерөнхий хороо, Нийслэлийн ИТХ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Эрчим хүчний зохицуулах хороо, Татварын ерөнхий газар, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Хөдөлмөрийн халамж, үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Авто тээврийн үндэсний төв, Нийслэлийн “Өргөө” амаржих газар, Баянгол дүүргийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Баянгол дүүргийн ИТХ, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв, “Эрдэнэс тавантолгой” ХК, “Нийслэлийн Орон сууцны корпорац” ХХК, “Дэлүүн” бүрэн дунд сургууль, Архангай аймгийн Байгаль орчин, аялал, жуулчлалын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Засаг дарга, Говь-Алтай аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ аймгийн Баянгол, Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар, Увс аймгийн Засаг даргын Тамгын газар, Увс аймгийн Түргэн сумын Засаг даргын Тамгын газар зэрэг нийт 53 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, чиглэл хүргүүлж, үр дүн биелэлтийг тооцон ажиллалаа.

Хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлын талаар нийт гомдол гаргагчдын 32.5 хувьд албан бичгээр, үлдэх хувьд нь амаар (утсаар, цахим шуудангаар) хариу өгчээ.

Шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулгын хувьд албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан үйлдэл 28.0 хувийг, хууль бус шийдвэр гаргаж бусдад давуу байдал олгосон 24.9 хувийг, ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан 20.6 хувь, хууль бус томилгоо 23.0 хувь, бусад 3.5 хувийг тус тус эзэлж байна.

Энэхүү үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан 8.0 хувиар, хууль бус томилгоотой холбоотой зөрчлийн талаарх мэдээлэл 3.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

6.6. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан талаар. Тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 16767 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл 156, нийт 16923 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэхээс тайлант хугацаанд 16512-ыг хянаж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, ажиллагаанд 411 мэдүүлэг хянагдаж байна. Хянавал зохих урьдчилсан мэдүүлгийн тоо 436 нэгжээр буюу 2.6 хувиар, хянасан мэдүүлгийн тоо 181 нэгжээр буюу 1.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 4. Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)**

Он	Хүлээн авсан	Өмнөх оны үлдэгдэл	Хянавал зохих	Хянасан	Үүнээс:				Ажиллагаанд
					АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчилтэй	Хуульд заасан үндэслэлээр буцаасан	
2023	16487	*	*	16331	15357	724	22	228	156
2024	16767	156	16923	16512	14604	1265	48	595	411


Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 48 этгээд тухайн албан тушаалд томилогдоход илт ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон тул энэ тухай томилох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хуульд зааснаар хянуулаагүй томилсон 29 томилох эрх бүхий албан тушаалтанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах сахилгын хариуцлага тооцуулж, цаашид энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар шаардлага хүргүүлэв.

### Долоо. Мөрдөн шалгах ажлын талаар:


7.1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл. 2024 онд гэмт хэргийн талаарх 1789 гомдол, мэдээллийг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл 114, нийт 1903 гомдол, мэдээллийг хүлээн авснаас 310 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн.

Дүрслэл 6. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангиллаар нь авч үзвэл, төрийн улс төрийн 238, төрийн захиргааны 470, төрийн тусгай 706, төрийн үйлчилгээний 147, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 170, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын 172 байна.

Дүрслэл 7. Гомдол, мэдээлэлд холбогдох албан тушаалтны ангилал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1513 гомдол, мэдээллээс 676 гомдол, мэдээлэл буюу 44.7 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 789 гомдол, мэдээлэл буюу 52.1 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 40 гомдол, мэдээлэл буюу 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 8 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 99.5 хувьтай буюу өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 2.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 8. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт  
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1513 гомдол, мэдээллийн 883 буюу 58.4 хувийг Улаанбаатар, 630 буюу 41.6 хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.

**7.2. Эрүүгийн хэргийн талаар.** Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 2216 үйлдэлтэй, 1436 холбогдогчтой, 1863 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг 2023 онд 1837 хэрэг шалгасантай харьцуулбал 1.4 хувиар өссөн байна.


Нийт шалгасан хэргийн 387 буюу 20.8 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 484 буюу 25.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 68 буюу 3.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 68 хэргийг нэгтгэн шалгаж, 31 хэргийг түдгэлзүүлж, одоо 825 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 756 хэрэг, мөрдөн байцаалтын 69 хэрэг байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 54.1 хувьтай, шүүхээр 216 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3.1 хувиар, шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг 12.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 9. Хэргийн шийдвэрлэлт  
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Дүрслэл 10. Ажиллагаанд байгаа хэрэг  
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах) гэмт хэрэг-1327 буюу 59.9 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл (Хахууль авах) гэмт хэрэг-270 буюу 12.2 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл (Хахууль өгөх) гэмт хэрэг-183 буюу 8.3 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах) гэмт хэрэг-23 буюу 1.0 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих) гэмт хэрэг-66 буюу 2.9 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах) гэмт хэрэг-36 буюу 1.6 хувь;
- Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах) гэмт хэрэг-63 буюу 2.6 хувь;
- Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл (Эрүү шүүлт тулгах) гэмт хэрэг-46 буюу 2.1 хувь;
- Бусад хэрэг 202 буюу 9.1 хувийг тус тус эзэлж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 133 буюу 9.3 хувийг төрийн улс төрийн, 290 буюу 20.2 хувийг төрийн захиргааны, 241 буюу 16.8 хувийг төрийн тусгай, 205 буюу 14.3 хувийг төрийн үйлчилгээний, 106 буюу 7.4 хувийг төрийн болон орон нутгийг өмчит хуулийн этгээдийн, 461 буюу 32.1 хувийг бусад этгээд эзэлж байна.

Дүрслэл 11. Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




2024 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 417 247 706 374 (дөрвөн зуун арван долоон тэрбум, хоёр зуун дөчин долоон сая долоон зуун зургаан мянга гурван зуун далан дөрөв) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 240 940 060 451 (хоёр зуун дөчин тэрбум, есөн зуун дөчин сая, жаран мянга, дөрвөн зуун тавин нэг) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 23 589 470 251 (хорин гурван тэрбум, таван зуун наян есөн сая, дөрвөн зуун далан мянга, хоёр зуун тавин нэг) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

2023 онд гэмт хэргийн улмаас учирсан 845 797 805 525 (найман зуун дөчин таван тэрбум долоон зуун ерэн долоон сая найман зуун таван мянга таван зуун хорин тав) төгрөгийн хохирлын 28.2 хувийг нөхөн төлүүлж байсан бол 2024 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас учирсан 417 247 706 374 (дөрвөн зуун арван долоон тэрбум, хоёр зуун дөчин долоон сая, долоон зуун зургаан мянга, гурван зуун далан дөрөв) төгрөгийн хохирлын 57.7 хувийг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэлт 29.5 хувиар, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 38.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хахуулийн 50 201 714 856.00 (тавин тэрбум хоёр зуун нэг сая долоон зуун арван дөрвөн мянга найман зуун тавин зургаа) төгрөгийн үнэ бүхий хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө, хураан авсан.

Дүрслэл 12. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



**7.3. Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар:** 2023 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 192 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2024 онд 216 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийг дурдвал:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд асан “А”, “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал “Г” нарын нэр бүхий 13 албан тушаалтанд холбогдох;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан “Э”, Зам, тээврийн хөгжлийн сайдаар ажиллаж байсан “Э” нарт холбогдох;
- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн Хүний нөөцийн хөгжил, сургалтын хэлтсийн даргаар ажиллаж байсан “А”-д холбогдох;
- “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын дарга “Б”, ерөнхий инженер “Б” нарт холбогдох;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийн газрын Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга “О”-д холбогдох;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн “Э”-д холбогдох;
- “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газрын дарга “Б” нарт холбогдох;
- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ахлах мэргэжилтэн “З”-д холбогдох;
- МУБИС-ийн Гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал “М”-д холбогдох;
- Өмнөговь аймгийн “Гурвансайхан орон сууцны корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал “Ц”-д холбогдох;
- Хөвсгөл аймгийн Ханх сумын Засаг дарга “Д”-д холбогдох;
- Улаанбаатар хотын Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга “З” нарт холбогдох;
- Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга “Н”-т холбогдох;
- “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал “Г”-т холбогдох;
- “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хангамж үйлчилгээний хэлтсийн дарга “Т”-д холбогдох;
- Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагч “А”-д холбогдох;
- Баянгол дүүргийн “Усан спорт, сургалтын төв” ОНӨААТҮГ-ын дарга “М”-д холбогдох;

- Дорноговь аймгийн Сайншанд дахь Гаалийн газрын Ханги боомтын эрхлэгч “М”-д холбогдох;
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын шүүх анагаах ухааны шинжилгээ хариуцсан мэргэшсэн шинжээч “Г” нарт холбогдох;
- Сонгинохайрхан дүүргийн Газар зохион байгуулалтын 2 дугаар албаны дарга “Л” нарт холбогдох;
- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн орлогч дарга “Г”-д холбогдох;
- Гаалийн ерөнхий газрын “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын хяналт шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч “Д”-д холбогдох;
- Гаалийн ерөнхий газрын Замын-Үүд дэх гаалийн газрын гаалийн улсын байцаагч “Б”-д холбогдох;
- Гаалийн ерөнхий газрын Гаалийн төв лабораторийн шинжээч, гаалийн улсын байцаагч “С”-д холбогдох;
- Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн татвар төлөгчдөд үйлчлэх тасгийн татварын улсын байцаагч “А”-д холбогдох;
- Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн ахлах нягтлан бодогч “Н”-д холбогдох;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэвлэл мэдээллийн хэлтсийн дарга “Г”-д холбогдох;
- Гадаадын иргэн, харьяатын газрын мэргэжилтэн “М”-т холбогдох;
- Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгө, эрхийн улсын бүртгэгч “О”-д холбогдох зэрэг хэргүүд шүүхээр шийдвэрлэгдээд байна.

Улсын ерөнхий прокурорын газрын прокурорын 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 4/04 дугаартай тогтоолыг үндэслэн Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн А/101, А/119, А/326 дугаартай тушаалаар томилогдсон нүүрс олборлолт, экспорт, боомтын нүүрсний тээвэрлэлт, төлбөртэй холбогдсон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын 21 мөрдөгч ажиллаж, 100 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас одоогийн байдлаар 16 хэргийн мөрдөн шалгах ажиллагааг дуусган шүүхэд шилжүүлэх саналтай, 14 хэргийг эрүүгийн хэрэгт нэгтгэх, 21 хэргийг хаах, 1 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай хэргийг Нийслэлийн прокурорын газрын прокурорын хяналтад шилжүүлж шийдвэрлэсэн. Ажлын хэсгээс шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн 16 хэргээс 86 холбогдогчтой 11 хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж, одоо хэрэг бүртгэлтийн 36, мөрдөн байцаалтын 12, нийт 48 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих прокурорын 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 4/02 тоот тогтоолын дагуу Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/34, А/134 дугаар хамтарсан тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын зээлийн сангаас төрийн өндөр албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүд хууль бус тэтгэлэг авч, эргэн төлөөгүй, мөн тэтгэлгийн мөнгийг хувийн дансаар авч завшсан, мөнгө угаасан байж болзошгүй гэх хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах ажлын хэсэг байгуулагдсан ба мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.

## ДҮГНЭЛТ

2024 онд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханган биелүүллээ гэж дүгнэж байна.

- Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2024 оны 5 дугаар сард Авлигатай тэмцэх газарт ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай танилцан, авлигын гэмт хэргийг илрүүлэх, гадаад улс руу оргон зайлсан этгээд болон гадаад руу хууль бусаар шилжүүлсэн хөрөнгийг буцаан авчрах чиглэлээр ажиллаж байгааг сайшааж, цаашид улс төр, бизнесийн явцуу ашиг сонирхолд үйлчлэх, улс орныхоо язгуур эрх ашгаас урвах, гэмт этгээдэд ял завшуулах, төрийн албаны нэр хүндийг бусдад худалдах, гэмгүй хүнийг хэлмэгдүүлэх, өөрсдөө бусдад худалдагдахын эсрэг байх, авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын арга барилаа өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлага байгааг онцлов.



- Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан болон Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын нэр бүхий гишүүд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцаж хууль, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд санал солилцлоо.

УИХ-ын дарга Д.Амарбаясгалан "...авлига бол хүний эрхийн хамгийн ноцтой зөрчил гэдгийг тодотгоод Монгол Улсад өргөн хэрэглэгдэж байгаа 318 хуулийн зүйл, заалт тус бүрд судалгаа хийхэд хүний эрхийн зөрчилтэй 800 гаруй заалт байгааг тогтоосон учраас энэ парламент тэдгээр зүйл заалтыг засахаар ажиллаж эхэлсэн..." талаар, нийгмийн харилцааны 70 хувийг журмаар зохицуулж байгаа нь авлига үүсэх, албан тушаалаа урвуулан ашиглах үндэс суурь болж буйг дурдав. УИХ-аас батлагдсан 2023-2030 онд хэрэгжих "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", 2024 онд батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа УИХ-д, олон нийтэд илүү мэдээлж байх, авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд анхаарлаа хандуулан ажиллах талаар үүрэг болголоо.

- Гүйцэтгэх ажлын хэлтэс, Мөрдөн шалгах хэлтсээс Дэлхийн банктай мэдээлэл солилцон, гадаад улсын ижил, төстэй чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажилласнаар Дэлхийн банкны 19.5 сая ам.долларын санхүүжилттэй "Цахим эрүүл мэнд" төслийн гүйцэтгэгч БНСУ-ын "Taihan Cable & Solution" компани нь хуурамч баримт бичиг бүрдүүлэх замаар төслийн сонгон шалгаруулалтад шалгарч, улмаар гэрээнд тусгагдсан төслийн хөрөнгийг үр дүнгүй захиран зарцуулж улсад их хэмжээний хохирол учруулсан болохыг тогтоосноор тус компаниас 1.7 сая ам.долларын хохирлыг Монгол Улсад эргүүлэн төлүүлж, төсвөөс дээрх зээлийн төлбөрийн хүүг төлж байсныг зогсоолоо. Авлигын гэмт хэргийн улмаас хулгайлагдсан нийт 13.9 сая ам.доллартай тэнцэх хэмжээний мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг улсын орлого болгоод байна.
- НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх албанаас авлигын улмаас хулгайлагдсан хөрөнгийг буцаан авчирч нийгмийн зорилтот бүлэгт чиглэгдсэн үйл ажиллагаанд зарцуулж байгаа туршлагыг онцолж, газар дээр нь нөхцөл байдалтай танилцлаа.
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээнээс Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторинг хийх үнэлгээний багийн үйл ажиллагаанд үндэсний зохицуулагчийн хувьд дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Үнэлгээнд 34 байгууллагын 165 албан тушаалтан хамрагдав. Олон улсын шинжээчдийн багаас Монгол Улсад ажиллах үед эрх бүхий байгууллага, албан тушаалтнудаас өгсөн болон нэмэлтээр хүргүүлсэн мэдээлэл, холбогдох бусад баримтад үндэслэсэн нэгдсэн тайланг тус Сүлжээний Жилийн бүгд хурлаар 2024 оны 9 дүгээр сард нийт гишүүн улсуудад танилцуулснаар тайланг хамгааллаа.
- Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсан тул Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.
- Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ийг шинэчлэн баталлаа. Тус хорооны дэд даргаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмж өгөх, олон



нийтэд мэдээлэх чиг үүрэгтэйгээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга томилогдон ажиллаж байна.

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны 2 удаагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэл ажлыг хангаж, хөтөлбөрт тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих чиглэлээр холбогдох асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, шийдвэрийг сурталчлах, олон нийтэд танилцуулах, мэдээ, мэдээллээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна.
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-тай хамтран Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилт, Хөрөнгө хураах тогтолцоо, Авлигаас урьдчилан сэргийлэх сэдэвт 3 бага хурлыг зохион байгуулж, Авлигатай тэмцэх газар болон холбогдох төрийн, төрийн бус байгууллагын 105 төлөөлөгчийг хамруулав. Бага хурлаар дэлхийн улс орнуудын авлигын эсрэг бодлого, тогтолцооны дутагдал, хүндрэл бэрхшээл, Монгол Улсын авлигын эсрэг шинэ стратеги, авлигаас урьдчилан сэргийлэх талаар санал солилцож, хөрөнгө буцаах олон улсын сайн туршлагыг танилцуулж, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдвэл зохих ажил, арга хэмжээг тодорхойллоо.
- Малайз Улсын Авлигатай тэмцэх хорооны тэргүүн комиссар Тан Шри Азам Бин Бакигийн урилгаар Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй төлөөлөгчид тус хороонд албан ёсны айлчлал хийж, авлигатай тэмцэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээг танилцуулан, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, энэ хүрээнд авлигатай тэмцэх чиглэлээр “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулах, тус улсын Авлигын эсрэг академитай хамтран байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохирлоо.
- Самоа Улсын Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын II, V бүлгийн хэрэгжилтийн хоёрдугаар шатны үнэлгээний багийн бүрэлдэхүүнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), Папуа Шинэ Гвиней Улсын шинжээчидтэй хамтран оролцож, Самоа Улсын хөрөнгө буцаах, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны талаарх тайланг үнэллээ.
- Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 05 дугаар тогтоолоор “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах журам”, холбогдох маягт, жагсаалтыг баталсан бөгөөд тус журамд нийцүүлэн “Мэдүүлэг гаргагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт нөхөх заавар”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн маягт нөхөх заавар”, “Нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарын маягт нөхөх заавар”-ыг баталлаа. Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлээд байна.
- Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдлээ.
- Байгууллагын хэмжээнд 2024 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гаргасан 2946 гомдол, мэдээлэл хүлээн авснаас Мөрдөн шалгах хэлтэс 1789 буюу 61.0 хувь, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс 828 буюу 28.1 хувь, Гүйцэтгэх ажлын хэлтэс 146 буюу 5.0 хувь, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс 115 буюу 3.9 хувь, Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын алба 66 буюу 2.2 хувь, Тамгын хэлтэс 2 буюу 0.1 хувийг хянан шалгасан байна.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)-ийн "Авлигыг мэдээлэх механизмыг боловсронгуй болгох нь" төслийн хүрээнд байгууллагын өргөдөл, гомдлын “Smart office” системд хөгжүүлэлт, интеграци хийж, all/call програмыг үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна. Тус програмыг нэвтрүүлснээр 110 тусгай дугаарын утсаар өргөдөл гомдол, санал, хүсэлт, талархал хүлээн

авах процессын үйл ажиллагаанд дэвшил гарч, чанаргүй дуудлагын тоо цөөрч, хийдэл болон зохиомол ачаалал буурсан эерэг үр дүн гарч байна.

- Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2020 онд хүүхдийн зохиолч Н.Мандалын зохиолоор Хүүхэлдэйн театртэй хамтран найруулагч М.Ариунтуяагийн найруулснаар “Хаалган хадны нууц” хүүхэлдэйн оролцоот хүүхдийн жүжгийг мэргэжлийн түвшинд тайзны бүтээл болгон туурвиж, ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нийт 1154 хүүхдэд үзүүлэв. Энэхүү арга хэмжээ нь хүүхэд, багачуудын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар буюу жүжгээр дамжуулан тэдэнд шударга ёсны үзэл хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн соён гэгээрүүлэх арга хэмжээ боллоо.
- Хяналт шалгалтын үйл ажиллагаанд албан тушаалтны үндэслэлгүй хөрөнгөжих, нуугдмал хөрөнгийг олж илрүүлэх чиглэлээр гадаад улс орны сайн туршлагыг судлах, эрх бүхий төрийн байгууллагатай хамтран ажиллах, чиг үүргийн уялдааг хангахад анхаарч ажиллав. Тухайлбал, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар 3 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газарт шилжүүлснээр шалгалтаар нийт 2 132 072 560 төгрөгийн татварын зөрчил илэрч, нийт 136 380 970 төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна.
- 2024 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас 417,2 тэрбум төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 240,9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 23,5 тэрбум төгрөгөөр үнэлэгдэхэд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна. 2024 онд шалгагдсан гэмт хэргийн улмаас учирсан 417,2 тэрбум төгрөгийн хохирлын 57.7 хувийг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэлт 29.5 хувиар, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 38.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хахуулийн 50.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө, хураан авсан.
- 2024 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн 216 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Цаашид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн ханган биелүүлэх, Монгол Улсад хэрэгжүүлэх мега төслүүдэд авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын арга барилыг өөрчлөн шинэчлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх, авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй олон улсын үр дүнтэй арга хэрэгсэл, туршлагыг судлан нэвтрүүлэхэд анхаарч ажиллах болно.